



ДАМЖУУЛАХ

Сүлжээ



ЦДҮС ТӨХК-ИЙН ХЭВЛЭЛ
www.transco.mn

2005 оноос эрхлэн гаргав.

№05 (149) 2020 оны 09 сар

ТӨРИЙН ДЭЭД ОДОН МЕДАЛИАР ШАГНАГДЛАА

Улсын их баяр наадмыг тохиолдуулан эрчим хүчний салбарт оруулсан хувь нэмэр, ажил хөдөлмөрөө үнэлүүлж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 172 дугаар зарлигаар Төрийн дээд шагнал "Алтангас" одонгоор Говийн бүсийн салбарын Санхүү, эдийн засгийн албаны дарга бөгөөд ахлах нягтлан бодогч Э.Оюунбат шагнагдаж, энгэрээ мялаалаа.



ЭРЧИМ ХҮЧНИЙ БОЛОН БУСАД САЛБАРЫН ШАГНАЛ ГАРДУУЛАВ

Эрчим хүчний салбарын ажилтны баярын өдрийг тохиолдуулан Монгол Улсын Эрчим хүчний сайдын 2020 оны 136, 146 дугаар тушаалаар эрхэлсэн ажилдаа амжилт гарган үр бүтээлтэй ажиллаж байгаа Шуурхай зохицуулалтын хэлтсийн диспетчер инженер Х.Лхагвасүрэн, Нийтлэг үйлчилгээ, тээвэр механизмын хэлтсийн цахилгаанчин Д.Пүрэвдорж, Төсөл хэрэгжүүлэх нэгжийн төслийн зохицуулагч Б.Батзориг, Улаанбаатар салбарын ээлжийн инженер Г.Батчулуун, ээлжийн техникч Ц.Мөнхбаяр, Төвийн бүсийн салбарын Шарын гол дэд станцын ээлжийн монтер Н.Эрдэнэбат, Засварын албаны дэд станцын засварын мастер М.Батцэнгэл, Говийн бүсийн салбарын дарга С.Намжилцэрэн, гагнуурчин Э.Дөлбадрах нар "Эрчим хүчний тэргүүний ажилтан" цол тэмдгээр, Шуурхай зохицуулалтын хэлтсийн диспетчер инженер П.Пүрэвсүрэн, Б.Ариунболд, Нийтлэг үйлчилгээ, тээвэр механизмын хэлтсийн тусгай зориулалтын автомашины жолооч Б.Бат-Оргил, Улаанбаатар салбарын ээлжийн инженер Г.Отгонбат, Төвийн бүсийн салбарын Борнуур дэд станцын ээлжийн инженер Б.Төрмөнх, Сүхбаатар дэд станцын ээлжийн техникч Д.Лхагва, Дархан дэд станцын ээлжийн техникч Г.Ганцэцэг, Говийн бүсийн салбарын Оюутолгой дэд станцын ээлжийн монтер Н.Батням нар Эрчим хүчний яамны "Жуух бичиг"-ээр, Зүүн-Өмнөд бүсийн салбарын Хэмжүүр, тоолуурын инженер М.Энхбаатар "Стандарт хэмжилзүйн тэргүүний ажилтан" цол тэмдгээр, Говийн бүсийн салбарын тооцооны нягтлан бодогч С.Цэрэнханд Сангийн яамны "Жуух бичиг"-ээр тус тус шагнуулсан.

НҮҮР-2

ЗҮҮН-ӨМНӨД БҮСИЙН
САЛБАРЫН 2019 ОНЫ
«ШИЛДЭГ 10 АЖИЛ»

НҮҮР-3

КОМПАНИЙН АХМАД НАСТНУУД
ГОВИЙН БҮСИЙН САЛБАРААР
ТОЙРОН АЯЛАЛ ЗОХИОН
БАЙГУУЛАВ

НҮҮР-3

110/35/10 КВ-ЫН САЙНШАНД
ДЭД СТАНЦЫН 30 ЖИЛИЙН
ОЙН БАЯР

НҮҮР-3

ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНИКИЙН
ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ БУС
ХУРЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ

НҮҮР-9

ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ
ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ ТӨХК-НИЙ
2020 ОНД ХИЙГДЭЖ БАЙГАА
ТОМООХОН АЖЛУУД

НҮҮР-12

ИХ БОЛОН УРСГАЛ
ЗАСВАРЫН АЖЛААР
ХИЙГДСЭН АЖЛУУД



Эрчим хүчний шагналаар шагнуулсан ажилтнууд



Эрчим хүчний тэргүүний ажилтан тэмдгээр шагнуулсан цахилгаанчин Д.Пүрэвдорж, төслийн зохицуулагч Б.Батзориг, ээлжийн инженер Г.Батчулуун, диспетчер инженер Х.Лхагвасүрэн, ээлжийн техникч Ц.Мөнхбаяр нар



Эрчим хүчний яамны "Жуух бичиг"-ээр шагнуулсан диспетчер инженер Б.Ариунболд, ээлжийн инженер Г.Отгонбат, жолооч Б.Бат-Оргил, диспетчер инженер П.Пүрэвсүрэн нар




"Стандарт хэмжилзүйн тэргүүний ажилтан" цол тэмдгээр шагнуулсан хэмжүүр, тоолуурын инженер М.Энхбаатар

ЗҮҮН-ӨМНӨД БҮСИЙН
САЛБАРЫН
2019 ОНЫ

“ШИЛДЭГ АЖИЛ”

1. РЕЛЕ ХАМГААЛАЛТ АВТОМАТИКИЙГ
ШИНЭЧЛЭВ

110/35/10 кВ-ын Сайншанд дэд станцад Өвөршанд 35 кВ-ын агаарын шугам болон Зүүнбаян-А 35 кВ-ын агаарын шугамын реле хамгаалалт автоматикийг шинэчлэх ажлаар хуучин реленүүдийг салгаж, шинээр SEL-751A реле суурилуулж, холболт хийж, тавил тохиргооны ажлыг гүйцэтгэсэн. Техник зохион байгуулалтын арга хэмжээний хүрээнд 110/35/6 кВ-ын Өндөрхаан, 110/6 кВ-ын Хот дэд станцын төв дохиоллын хэлхээг шинэчлэн SEL-2523 маркийн микропроцессорын төв дохиоллын реле суурилуулан реле хамгаалалт автоматикийн найдвартай ажиллагааг дээшлүүлсэн.

2. ПАРК ШИНЭЧЛЭЛТ
ХИЙГДЭВ

Салбарын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу ЦДҮС ТӨХК-ийн Зүүн-Өмнөд бүсийн салбарын конторт Бонго пронтер болон 220/110/35/6 кВ-ын Чойр дэд станцад УАЗ фургон автомашин хүлээн авч, парк шинэчлэлт хийсэн.

3. ҮНДСЭН ХАМГААЛАЛТ ОРУУЛАХ
АЖИЛ ХИЙГДЭВ

Төвийн эрчим хүчний системтэй Гэгээ Нар 15МВт НЦС, Шанд 55МВт СЦС, Сүмбэр нар 10МВт НЦС, Цэций 50МВт СЦС зэрэг Сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрүүд системд холбогдож, систем үүсгэгч транзит цахилгаан дамжуулах агаарын шугамын үндсэн хамгаалалттай болгох ажлын хүрээнд 207 дугаар агаарын шугам, Чойр-Айраг, Айраг-Сайншанд, Сайншанд-Замын-Үүдийн 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамуудад ПВЗУ-Е маркийн ВЧ пост ашигласан өндөр давтамжийн хоригтой үндсэн хамгаалалт шинээр ашиглалтад оруулав.

4. АККУМУЛЯТОРЫН БАТАРЕЙН ШУЛУУТГАГЧ
ТӨХӨӨРӨМЖ СУУРИЛУУЛАВ

110/6 кВ-ын Хот дэд станцад аккумуляторын батарейн шулуутгагч төхөөрөмж шинээр суурилуулан дэд станцын төв дохиолол, реле хамгаалалт, аваарын гэрэлтүүлгийг тэжээв.

9. АНХНЫ ТУСЛАМЖИЙН НӨХӨРЛӨЛ ТЭМЦЭЭНД
АМЖИЛТАЙ ОРОЛЦОВ

Монгол Улсын зүүн бүсийн "Анхны тусламжийн нөхөрлөл"-ийн тэмцээнд Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн Зүүн-Өмнөд бүсийн салбарын "Зөв" баг Багануур дүүргийг төлөөлөн оролцож, гуравдугаар байр эзлэв.

5. 35 КВ-ЫН ТОСОН ТАСЛУУРЫГ ВАКУМ
ТАСЛУУРААР СОЛИВ


110/35/6 кВ-ын Өндөрхаан дэд станцын Өлзийт 35 кВ-ын ТТ, 110/35/6 кВ-ын Бор-Өндөр дэд станцын Дархан 35 кВ-ын ТТ-г тус тус Вакум таслуураар сольж, реле хамгаалалт автоматикийг SEL-751A маркийн МП хамгаалалтаар шинэчлэх ажлыг гүйцэтгэсэн. Айраг, Сайншанд, Замын-Үүд, Борхой дэд станцын хүчний трансформаторуудад иж бүрэн хэмжилт туршилтын ажил хийгдсэн.

6. АЙРАГ ДЭД СТАНЦЫН Т-1, Т-2
ТРАНСФОРМАТОРТ ИХ ЗАСВАРЫН АЖИЛ ХИЙВ


110/35/10 кВ-ын Айраг дэд станцын Т-1, Т-2 трансформаторын их засварын ажлаар трансформаторын тос цэвэрлэх болон тосны шүүрэлт зогсоох, хэмжилт, туршилт хийх, реле хамгаалалт шалгах ажил хийж гүйцэтгэв.

7. ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ АГААРЫН ШУГАМД ҮЗЛЭГ, ОНОШИЛГОО
ХИЙХ ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИЙГ НЭВТРҮҮЛЭВ

Дрон ашиглан цахилгаан дамжуулах агаарын шугамд үзлэг, оношилгоо хийх дэвшилтэт технологийг нэвтрүүлж, үзлэгээр илрүүлэх боломжгүй агаарын шугамын элемент, тусгаарлах болон бэхлэгээний хийц хэсгүүдэд үүсэж байгаа гэмтлийг агаарын шугам хүчдэлтэй байхад нь илрүүлж, оношлох аргыг ХБНГУ-ын Кемницийн техникийн их сургуулийн эрдэмтэн, багш нартай хамтран гүйцэтгэв. Ингэснээр агаарын шугамын гэмтлийг урьдчилан илрүүлж, тасралт гарах эрсдэлийг бууруулна. Тухайлбал 207 дугаар цахилгаан дамжуулах агаарын шугамд гарсан тасралт, гэмтлийн цэг заасан хэсгийн дагуу тулгуур №110-400 хооронд дронаар түүвэрчилсэн үзлэг хийхэд 13 гэмтэл илрүүлж, илэрсэн гэмтлийг арилгаж, дахин тасралт гарахаас урьдчилан сэргийлж чадсан.

8. 110/10 КВ-ЫН ШИРЭЭТ ДЭД СТАНЦ, 110 КВ-ЫН НЭГ ХЭЛХЭЭТ 18,3
КМ ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ АГААРЫН ШУГАМД УЛСЫН КОМИСС
АЖИЛЛАЖ, АШИГЛАЛТАД ХҮЛЭЭН АВАВ

Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт баригдаж байгаа Газрын тос боловсруулах үйлдвэрийг цахилгаан эрчим хүчээр хангах Ширээт 110 кВ-ын нэг хэлхээт 18,3 км цахилгаан дамжуулах агаарын шугам, 110/10 кВ-ын 6300 кВа хүчин чадалтай нэг трансформатор, 10 кВ-ын 9 ячейктай Ширээт дэд станцад 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдөр улсын комисс ажиллаж ашиглалтад хүлээн авч туршилтын 72 цагийн хүчдэлд залгав. Энэхүү бүтээн байгуулалтын ажил эрчим хүчний салбарын 2018 оны "Шилдэг бүтээн байгуулалтын ажил"-аар шалгарсан.

10. ЧАДАМЖИЙН ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ
СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАВ

ЦДҮС ТӨХК-ийн сургалтын төлөвлөгөөний дагуу Зүүн-Өмнөд бүсийн салбарын сургалтын төвд 2019 онд нийт зургаан удаагийн 440 цагийн Чадамжийн гэрчилгээ олгох болон эрх сунгах ахисан түвшний сургалтыг зохион байгуулсан. Сургалтад харьяа салбаруудын 91 ажилтан хамрагдсан.



Зүүн-Өмнөд бүсийн салбарын 2019 оны ажлын тайлангаас



КОМПАНИЙН АХМАД НАСТНУУД ГОВИЙН БҮСИЙН САЛБАРААР ТОЙРОН АЯЛАЛ ЗОХИОН БАЙГУУЛАВ

(Улаанбаатар-Мандалговь-Цагаансуварга-Даланзадгад-Ёлын ам-Мандалговь-Их газрын чулуу-Улаанбаатар) аяллын дурсамж

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн ахмад настан, эрчим хүчний гавьяат ажилтан Д.Жанчиваар ахлуулсан аяллын баг 1500 орчим км замыг туулж, хөгжилтэй, адал явдалтай, сайхан аялаад ирлээ. Бид 2020 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн өглөө Улаанбаатар хотоос аяллын гараагаа эхэлж, 275 км замыг туулан ирсэнд биднийг биднийг хүлээн авч үдийн зоог барьж дайлсан Говийн бүсийн салбарын хамт олондоо ажлын өндөр амжилт хүсье.

Мөн цааш үргэлжлүүлэн 185 км зам туулж, Дундговь аймгийн Өлзийт сумын нутагт байрлах Цагаан суварга жуулчны баазад хоноглов. Маргааш өдөр буюу 2020 оны 09 дүгээр сарын 05-ны өглөө говийн үзэсгэлэнт сайхан тогтоц бүхий Цагаан суваргыг үзэж, дурсгалын зураг авахуулаад тэндээсээ 200 км орчим зам туулж, Өмнөговь аймгийн нутагт орших Ёлын ам хүрээ. Ёлын амаар аялан жуулчилж зураг татуулж, зарим нь морь унаж зугаалаад оройдоо жуулчны баазад хоноглон аяллын дурсамж яриа өрнүүлэн амарлаа.

Ёлын амны жуулчны баазад 2020 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн өглөө хөдөлж, 355 км зам туулан Мандалговь хотод үдийн зоог барив. Мандалговь хотоос цааш 90 км шороон замаар явж, Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт байдаг Их газрын чулуу хэмээх газар очиж, Тоонотын агуй, Лянх хад зэргийг үзэж сонирхлоо. Тэр сайхан байгалийн тогтоцыг мялааж цээл тунгалаг хоолойгоор ахмад настан Д.Ганзориг уртын дуу уянгалуулан дууллаа, ахмад настан Б.Цээнхүү "Үлэмжийн чанар" дууг төгс сайхан дуулж байгаль дэлхийгээ баясгалаа. Бид эндээсээ Дундговь аймгийн Дэлгэрцогт сум хүртэл 110 км шороон замаар Дэлгэрцогт сумаас цааш 235 км замыг засмал замаар туулж Улаанбаатар хотдоо ирсэнээр аяллаа өндөрлүүлсэн.

Замын турш ая дууг манлайлан дуулж, хөгжөөн явсан Б.Цээнхүүг шилдэг дуучнаар, нэгэн үдшийг хөгжөөн цэнгүүлж, "хөөрхөн" байж чадсан Л.Болормааг шилдэг миссээр, аяллын замын турш хөгжим, караоке, микрофоноор үйлчилж, бүжиг, диско зохиож, тоглоом наадмаар хөгжөөж чадсан шилдэг урлагийн менежерээр С.Болдыг, аяллын турш эрт босож цай чанан, дээж өргөж багийнхныгаа халамжилж явсан Г.Саранцэцэгийг шилдэг эртэч ажилсаг бүсгүйгээр, хамгийн энгийн, даруу гүндүүгүй залуугаар Б.Жаргал, Ш.Цогтбаатар нарыг, хамгийг хөгжөөн баясгагч, шилдэг бүжигчин бүсгүйгээр О.Гэрлээг, мөнхийн залуу хатагтайгаар өндөр настан Б.Хашааг, бүсгүйчүүдийг уяраан татдаг шилдэг залуугаар алтан гургалдай мэт яруу тунгалаг хоолоотой уртын дуучин Д.Ганзоригийг, шилдэг аяллын зураглаачаар С.Зоригтыг, шилдэг нийтэч бүсгүйгээр Л.Даваажавыг, замын турш үндэсний дээлээрээ гоёсон, гадаад улсад зорчихдоо ч үндэсний монгол дээлээрээ гоёдог, шилдэг үндэсний соёл уламжлалаа дээдлэгч бүсгүйгээр Д.Одмааг, эвлэг зөөлөн харьцаатай, энхрий ялдам бүсгүйгээр С.Оюунцэцэгийг, маш хурдан гүйж аяллын үзвэрийг бүрэн үздэг шилдэг хурдтай аялагчаар Ш.Чулуунцэцэг, Н.Мягмаржав нарыг, шилдэг хамт олонч бүсгүйгээр О.Алтанцэцэгийг, гоё ганган даашинзаараа мэлмий баясгасан шилдэг ганган бүсгүйгээр Р.Ундармаа, Б.Сүнжидмаа нарыг тус тус аяллын явцад шалгаруулсаар явж ирлээ.

*Аяллын ерөнхий зохион байгуулагч
Аж үйлдвэрийн гавьяат ажилтан Д.Жанчив
Туслах зохион байгуулагч Н.Адъяабазар*

ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ ТӨХК-НИЙ ЗҮҮН-ӨМНӨД БҮСИЙН САЛБАРЫН 110/35/10 КВ-ЫН САЙНШАНД ДЭД СТАНЦЫН 30 ЖИЛИЙН ОЙН БАЯР

110/35/10 кВ-ын Сайншанд дэд станцын 30 жилийн ойн баярын арга хэмжээ 2020 оны 08 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулагдаж, ээлжийн инженер Б.Мөнхжаргал, ээлжийн инженер П.Болдхуяг, ээлжийн инженер Э.Амаржаргал, засварын монтёр Б.Батхуяг, ээлжийн монтёр М.Жамсран, ээлжийн инженер Ж.Оюунгэрэл нар Дорноговь аймгийн Засаг даргын "Жуух бичиг"-ээр, ээлжийн инженер П.Болдхуяг Монголын залуучуудын холбооны "Тэргүүний залуу" алтан медаль, ээлжийн монтёр А.Ууганбат Монголын залуучуудын холбооны "Хөдөлмөрийн алдар" медалиар тус тус шагнууллаа.



ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНИКИЙН ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ

Компанийн үйлдвэрлэл, техникийн зөвлөлийн ээлжит бус хурал 2020 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр компанийн хурлын танхимд цахим хэлбэрээр зохион байгуулагдаж, Дэлхийн банкны төслийн "Цахилгаан эрчим хүчний систем үүсгэж буй өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах сүлжээний реле хамгаалалт, автоматикийн байгууламжид техникийн аудит хийсэн зөвлөх үйлчилгээний ажлын дунд хугацааны тайлан"-г хэлэлцэв. Хурлыг Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн тэргүүн дэд захирал бөгөөд ерөнхий инженер Б.Дашдаваа удирдаж, Шинжлэх ухаан технологийн их сургуулийн багш нар, ОХУ-ын Парма, Шугам компаниудын төлөөлөл, хурлын гишүүд болон Дэлхийн банкны төсөл хэрэгжүүлэх нэгжийн удирдагч, инженерүүд оролцов.





УЛААНБААТАР САЛБАР

ХАБЗА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

Салбарын хэмжээнд 2020 оны 07, 08 дугаар сард нийт 4470 ажилтанд өдөр тутмын зааварчилгаа, 10 ажилтанд урьдчилсан зааварчилгаа өгч, ажил гүйцэтгэх бригадуудад өдөр бүр 8.00-8.15 цагийн хооронд хөдөлмөрийн аюулгүй байдлын цуглаан зохион байгуулж, тухайн ажлын онцлогт тааруулан өдөр тутмын зааварчилгаа өгч ажилласан. Агаарын шугам 208-ын хөндийрүүлэг солих ажил, 203, 204-ийн будгийн ажил, агаарын шугам 205, 206-ын аянгын троссыг шилэн кабелиар солих ажилд томиллоор ажилласан шугамын засварын бригадэд зааварчилгааг цаг тухай бүрт өгсөн.



Гадны бригадэд өгсөн зааварчилгаа:

Агаарын шугам 205, 206-ын аянгын троссыг шилэн кабелиар солих ажилд Эрчим инженеринг ХХК-ийн 16 ажилтанд зааварчилгаа өгч, ажил эхлүүлэх зөвшөөрөл №01 олгон ХАБЭА-н инженер Ш.Чулуунсүрэн хяналт тавьж ажилласан. Баруун дэд станцын 10 кВ-ын I, II секцэд автомат удирдлагатай реактор, фильтр, хуурай салгуур суурилуулах, реле хамгаалалтын тавил туршилт, тохируулгын ажил гүйцэтгэх Эрчим Электр ХХК-ийн 10 ажилтанд зааварчилгаа өгч, ажил эхлүүлэх зөвшөөрөл №02 олгож ажилд нь оруулсан.

220/110/35 кВ-ын Улаанбаатар дэд станцад агаарын шугам 107, 108-ын төгсгөлийн анкераас шугамын портал хооронд утас солих ажлыг гүйцэтгэх Цагаанхорол ХХК-ийн 16 ажилтанд зааварчилгаа өгч ХАБЭА-ийн инженер Л.Ариунболд хяналт тавин ажилласан.

Ээлжит бус зааварчилгаа:

- Өндөржүүлсэн бэлэн байдалд шилжих хугацааг сунгасан талаар салбарын нийт ажилтнуудад ээлжит бус зааварчилгаа өгсөн.
- Эрчим хүчний яамнаас ирүүлсэн Ховдын цахилгаан түгээх сүлжээ компанийн ослын мэдээлэл, албан даалгаврын мөрөөр, ослыг гарахад нөлөөлсөн Аюулгүй ажиллагааны дүрмийн заалтуудаар салбарын нийт ажилтнуудад ээлжит бус зааварчилгаа өгөв
- Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-д гарсан ослын мөрөөр ирсэн СМД03/2020 нийт ажилтнуудад танилцуулж зааварчилгаа өгсөн.
- Дорнод бүсийн эрчим хүчний систем, Дархан-Уул аймагт гарсан зөрчил, өндөржүүлсэн бэлэн байдал зарласантай холбогдуулан ээлжит бус зааварчилгаа өгсөн.

Хяналт шалгалтын чиглэлээр:

- Эрчим хүчний хөгжлийн төвөөс 2020 оны 07 дугаар сарын 27-ны өдрөөс 2020 оны 07 дугаар сарын 31-ний өдрүүдэд хийгдсэн шалгалтын мөрөөр, компанийн гүйцэтгэх захирлын "Өндөржүүлсэн бэлэн байдалд шилжүүлэн ажиллуулах тухай" 2020 оны 07 дугаар сарын 31-ны өдрийн А/169 дүгээр тушаал, 2020 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн 01/1179 тоот зөвлөмж, тэргүүн дэд захирал бөгөөд ерөнхий инженерийн

2020 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 02/1207 тоот төлөвлөгөө, 2020 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 02/1300 тоот сэрэмжлүүлэх мэдээлэл даалгаврын мөрөөр хийгдэх төлөвлөгөөг хэрэгжүүлэх, ажилтнуудын ажлын хариуцлага, сахилга батыг дээшлүүлэх, аваар саатлаас урьдчилан сэргийлэх зорилгоор гэнэтийн үзлэг шалгалтын удирдамж боловсруулж, үзлэг шалгалтыг явуулж байна.



Агаарын шугам 203, 204 будгийн ажил хийгдэж байгаа байдал

- Гео дэд станцын хашаа гэмтээсэнтэй холбоотойгоор Вендо ХХК-аар үнэлгээ хийлгэж 775156 төгрөгийн зардал гарсан тул Сонгинохайрхан дүүргийн замын цагдаагийн албанд хүсэлт гарган хэрэг үүсгэсэн.

- 2020 оны 08 дугаар сарын 07-ны өдөр салбарын цайны газарт хийх үзлэг шалгалтын удирдамж боловсруулж, бүх албадын төлөөлөл хамтран үзлэг шалгалт зохион байгуулж, дүнг салбарын удирдлагуудад танилцуулж, цайны газрын үйл ажиллагаа, хоолны амт чанар, эрүүл ахуйг сайжруулах талаар зөвлөмж өгч ажилласан.

Хамгаалалтын зурвасын чиглэлээр:

- Агаарын шугам 203, 204-ийн тулгуур №45-46 хооронд хамгаалалтын зурваст агуулах барьсан иргэн А.Энхсайханд улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлсэн.
- Агаарын шугам 205, 206, 208 хамгаалалтын зурвас зөрчсөн Баянгол дүүргийн 20 дугаар хороонд байрлах ЭВТ Төмөр ХХК-тай ХМХ-ийн дарга, ХАБЭА, ДШС ТӨХК хяналтын хэлтсийн ажилчин, улсын байцаагч, БГД-ийн газар зохион байгуулагч нар газар дээр нь уулзан дэглэм сахиулах чиглэлээр үүрэг даалгавар өгч хурлын протокол үйлдэн баталгаажуулсан.
- Салбарын урд талын хамгаалалтын зурвасын дэглэм сахиулах ажлын хүрээнд БГД-ийн ТНААХ, тээврийн цагдаагийн алба, МХХ, Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс, дүүргийн газар зохион байгуулалтын албанд албан тоот хүргүүлэн, холбогдох байгууллагуудтай уулзан хамгаалалтын зурваст зогоон татах ажлыг эхлүүлсэн. Тус ажлын хүрээнд Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн БТТ кабелийн тросс чагнуулла, УБДШС дулааны шугамын трассын тодруулга хийлгэн хамгаалалтын зурвасын хашаа бариулах ажлыг эхлүүлээд байна.

АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

Их засварын ажлыг дараах тоноглолд хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- 110/35/10 кВ-ын Дорнод-2 дэд станцын 35 кВ-ын Гачуурт ГТ
- 110/35/10 кВ-ын Дорнод-2 дэд станцын 35 кВ-ын Гачуурт ШинС
- 110/35/10 кВ-ын Дорнод-2 дэд станцын 35 кВ-ын Гачуурт ШуС
- 110/35/10 кВ-ын Дорнод-2 дэд станцын 35 кВ-ын СХТ ШинС-1
- 110/35/10 кВ-ын Дорнод-2 дэд станцын 35 кВ-ын СХЭТ-н ГТ-1
- 110/35/10 кВ-ын Дорнод-2 дэд станцын Т-1 35 кВ-ын ГТ
- 110/35/10 кВ-ын Дорнод-2 дэд станцын Т-1 35 кВ-ын Тр.С
- 110/35/10 кВ-ын Дорнод-2 дэд станцын Т-1 35 кВ-ын ШинС
- 110/35/10 кВ-ын Дорнод-2 дэд станцын Т-2 35 кВ-ын ГТ
- 110/35/10 кВ-ын Дорнод-2 дэд станцын Т-2 35 кВ-ын Тр.С
- 110/35/10 кВ-ын Дорнод-2 дэд станцын Т-2 35 кВ-ын ШинС
- 110/10/6 кВ-ын Өмнөд дэд станц 110 кВ-ын 1-р секцийн портал
- 110/10/6 кВ-ын Өмнөд дэд станц Т-1 трансформатор
- 110/10/6 кВ-ын Өмнөд дэд станц ДХТ-1 ГТ тэргэнцэр
- 110/10/6 кВ-ын Өмнөд дэд станц Т-2 трансформатор
- 220кВ-ын агаарын шугам 203, 204-ийн тулгуур №219-190-ийг мөнгөн боронзоор будах

Урсгал засварын ажлын хүрээнд дараах тоноглолд засвар хийв. Үүнд:

- 110/35/10 кВ-ын Дорнод-2 дэд станцын 35 кВ-ын СХЭТ
- 110/35/10 кВ-ын Дорнод-2 дэд станцын 35 кВ-ын Гачуурт ЭТ
- 110/35/10 кВ-ын Дорнод-2 дэд станцын Т-1 35 кВ-ын ЭТ
- 110/35/10 кВ-ын Дорнод-2 дэд станцын Т-2 35 кВ-ын ЭТ
- 220/110 кВ-ын ИХБ-4 220 кВ-ын ХТ-1
- 220/110 кВ-ын ИХБ-4 220 кВ-ын ХТ-3
- 220/110 кВ-ын ИХБ-4 220 кВ-ын ХТ-1-н ШинС
- 220/110 кВ-ын ИХБ-4 110 кВ-ын Шин.ТойТ-1-н ШинС-1
- 220/110 кВ-ын ИХБ-4 110 кВ-ын ХТ-3
- 220/110 кВ-ын ИХБ-4 220 кВ-ын ТойСШ ХТ-1
- 220/110 кВ-ын ИХБ-4 220 кВ-ын ТойСШ ХТ-2
- 220/110 кВ-ын ИХБ-4 110 кВ-ын ТойСШ ХТ-1
- 220/110 кВ-ын ИХБ-4 110 кВ-ын ТойСШ ХТ-2

Засвар шинэчлэлээр хийгдсэн томоохон ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: Улаанбаатар салбарын 18 ажилтны бүрэлдэхүүнтэй шугамын бригад 220 кВ-ын 205, 206 дугаар цахилгаан дамжуулах агаарын шугамын тулгуур №1-88-ийн хооронд аянгын троссыг шилэн кабель бүхий троссоор солих ажлыг 2020 оны 08 дугаар сарын 12-26-ны өдрүүдэд хийж гүйцэтгэсэн.



110/10/6 кВ-ын Өмнөд дэд станцын ДХТ-1 ороомгийг сушилк-д хатаах ажил



110/10/6 кВ-ын Өмнөд дэд станцын ДХТ-1 их засварын ажил

ЦАГ ҮЕИЙН АЖЛААР

МОНГОЛЫН ЗАЛУУ ИНЖЕНЕРҮҮДИЙН ХОЛБООНООС ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН "ХӨГЖЛИЙН ШИЙДЭЛ-1" ЦУВРАЛ УУЛЗАЛТАД ОРОЛЦОВ

Монголын залуу инженерүүдийн холбооноос 2020 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр зохион байгуулсан эрчим хүчний салбарын тогтолцоог боловсронгуй болгох, сэргээгдэх эрчим хүч, дэд бүтцийн орчныг сайжруулах, эрчим хүчний хэмнэлт үр ашгийг дээшлүүлэх, инновацийг дэмжих, шинэ техник технологи нэвтрүүлэх талаар инженерүүдийн санаа бодлыг сонсож, төрд хүргэх, төрийн бодлого шийдвэрийн хүрээнд хамтран ажиллахаар зохион байгуулагдсан "Хөгжлийн шийдэл-1" цуврал уулзалтад тус салбарын нийлмэл реле хамгаалалтын инженер Д.Төмөр-Очир, ээлжийн инженер Г.Хангай нар оролцон санал бодлоо солилцлоо.



Улаанбаатар салбарын сургалт, бүтээмжийн инженер Б.Цолмончимэг



ТӨВИЙН БҮСИЙН САЛБАР

ХАБЗА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

2020 оны 07 дугаар сард тус салбарын ХАБЭА, техник хяналт, санхүү, цайны газрын үйл ажиллагаанд компаниас дотоод хяналт шалгалт хийгдсэн. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах төлөвлөгөө батлуулан ажиллаж байгаа бөгөөд 08 дугаар сарын гүйцэтгэлээр 82% биелэлттэй ажиллаж байна. Үүнд:

№	Төрөл чиглэл	Үүрэг даалгавар	Бүрэн хэрэгжсэн	Дутуу гүйцэтгэлтэй	Гүйцэтгэл / % /
1	Цайны газар	8	7	1	87,5
2	Санхүүгийн дотоод хяналт	4	3	1	75
3	ХАБЭА, техник хяналт	16	13	3	81,3
Дүн		28	23	5	82

2020 оны 07, 08 дугаар сард хийгдэх төлөвлөгөөт их болон урсгал засвар, ТЗБАХ-ний нэр төрлөөр нийт 55 нэгж ажил гүйцэтгэх үеийн эрсдэлийн үнэлгээ боловсруулж, түүний мөрөөр тухайлсан зааварчилгаа өгч ажилласан.

Шарын гол, Ерөө дэд станцын барилгын засвар, Борнуур, Сүхбаатар дэд станцын ТЗБАХ-ний ажил, 110 кВ-ын 113, 114 дүгээр цахилгаан дамжуулах агаарын шугамын хамгаалалтын зурваст барилга угсралтын ажил гүйцэтгэх зэрэг нийт 11 гадны байгууллагад зөвшөөрөл олгож, 24 ажилтанд урьдчилсан зааварчилгаа өгч ажилласан.

Салбар дотооддоо Орхон дэд станцын Т-1-ийн хамгаалалт ажиллаж хүчдэлгүй болсон, 110 кВ-ын Үйлдвэр-А агаарын шугамд аянга бууж, Үйлдвэр дэд станц хүчдэлгүй болсон технологийн зөрчлүүдийг судлан бүртгэсэн.

2020 оны хөдөлмөр хамгааллын зориулалтаар 133 ажилтанд зуны ажлын хувцас, 116 ажилтанд зуны ажлын гутал олгож, салбарын 18 дэд станц, конторын өрөө тасалгаанд нийт 910,0 мянган төгрөгийн эм хэрэгслийн нөхөн хангалт хийсэн.

Дарханы дулааны цахилгаан станцын 110 кВ-ын Хаалттай хуваарилах байгууламж, Дархан, Үйлдвэр, Бурхант, Тосгон, Давхар дэд станцуудад ажлын байрны гуравдугаар шатны үзлэг хийж 36 зөрчил илрүүлэн, хугацаатай үүрэг даалгавар өгч, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.

Шинээр ажилд орсон, ажлын байр өөрчлөгдсөн зургаан ажилтанд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Аюулгүй ажиллагааны дүрэм, тухайн дэд станцын онцлог, суурилагдсан реле хамгаалалт автомажикийн байгууламж, хэмжилт туршилтын төрөл, норм сэдвээр 32 цагийн танхимын сургалт зохион байгуулсан.

Компанийн хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдалд шилжин ажиллаж байгаатай холбогдуулан 2020 оны 07 дугаар сарын 05, 2020 оны 08 дугаар сарын 27-ны өдрүүдэд зарлан дуудах схемээр нийт ажилтны бэлэн байдлыг шалгаж, салбарын дарга, ерөнхий инженер, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн инженерүүдийн зүгээс заавар, зөвлөмж өгч ажилласан.

COVID-19 вирусийн тархалтаас урьдчилан сэргийлэх чиглэлээр өдөр тутам конторын ажилтнуудын халууныг хэмжиж, хоолой ам зайлах, конторын үүдний дэлгэцээр ЭМЯ-ны мэдээллийг нийтэд мэдээлэх зэрэг үйл ажиллагаа тогтмол хийгдэж байна.

АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

Орхон, Хөтөл, Борнуур, Дулаанхаан, Сүхбаатар дэд станцын реле хамгаалалт автомажикийн байгууламжийн урсгал засвар, Бурхант дэд станцын электрон тоолууруудыг баталгаажуулах, Орхон дэд станцын хэмжүүрийн урсгал засварын ажлыг хийж гүйцэтгэсэн.



Цэнэглэх байгууламж болон аккумуляторын байгууламж

110/35/10 кВ-ын Баясгалант дэд станцын трансформаторын хамгаалалт СВ-35, СВ-6 кВ-ын хамгаалалт болон төв дохиоллыг микропроцессорын релегээр бүрэн шинэчлэх ТЗБАХ-ний ажлыг хийж гүйцэтгэсэн. Ингэснээр алслагдсан Баясгалант дэд станцын оператив тэжээл үүсгэгч болон Т1, Т2 трансформаторын хамгаалалт, 35 кВ-ын хамгаалалтууд бүрэн микропроцессорын хамгаалалтаар үе шаттай шинэчлэгдэн найдвартай ажиллагааг дээшлүүлсэн.



110/35/6 кВ-ын Сүхбаатар дэд станцын трансформаторын хамгаалалт, төв дохиолол, 6 кВ-ын II секцийн гарсан шугамын хамгаалалт, 6 кВ-ын болон 35 кВ-ын СХТ, 35 кВ-ын Албанбулаг, Шаамар цахилгаан дамжуулах агаарын шугамын хамгаалалтыг микропроцессорын хамгаалалтаар шинэчлэх ажил хийгдэж, аккумуляторын байгууламж, цэнэглэх байгууламжийг шинээр суурилуулж ажилд оруулсан.



6 кВ-ын II секцийн ячейкуудыг шинэчилсэн байдал



ОПУ-д хамгаалалтын 9 панель буулгасан. Хамгаалалт, удирдлага, дохиоллын хэлхээ нь 5 панелд суурилагдсан.



ТӨЛӨВЛӨГӨӨТ ИХ ЗАСВАРЫН АЖИЛ

220/110/35 кВ-ын Дархан дэд станцын АТ-1, 2 автотрансформатор, 110 кВ-ын I, II СШ, 35 кВ-ын I, II СШ-ын холболтууд, 110/35/6 кВ-ын Хөтөл, 110/35/10 кВ-ын Орхон, Борнуур, Сүхбаатар дэд станцын анхдагч тоноглолд ээлжит урсгал засварын ажлыг хийж гүйцэтгэсэн.



110 кВ-ын Хөтөл, Орхон, Сүхбаатар, 116, 208 дугаар цахилгаан дамжуулах агаарын шугамын ээлжит урсгал засварын ажлыг хийж гүйцэтгэсэн.

ТӨЛӨВЛӨГӨӨТ БУС ЗАСВАРЫН АЖИЛ

110 кВ-ын Орхон агаарын шугамын тулгуур №14-18 хооронд АС-70 маркийн утас солих ажлыг гүйцэтгэж, шинэ хуучин утасны дээжийг шинжилгээнд оруулах ажил хийгдэж байна.

110/6 кВ-ын Үйлдвэр дэд станц дээр аянга бууж, гэмтэл устгах ажлаар ил хуваарилах болон хаалттай хуваарилах байгууламжийн үерийн ус соруулах, Т-1 трансформаторын 6 кВ-ын нэвтрэх оруулга, тулах изолятор солих ажлыг гүйцэтгэсэн.



Төвийн бүсийн салбарын компьютерын инженер Н.Оюунболд



ХАНГАЙН БҮСИЙН САЛБАР

◀ ХАБЗА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ ▶

Салбарын хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр 2020 оны 07, 08 дугаар сард дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

Наряд, шийдвэрээр салбарын харьяа нийт 12 дэд станцын тоног төхөөрөмж болон 110 кВ, 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамд нарыдаар 86, шийдвэрээр 172 удаагийн ажил гүйцэтгэж, ажил гүйцэтгэх бригадын 611 ажилтанд тухайлсан зааварчилгаа өгч, зөрчил дутагдалгүй ажилласан.

Салбарт шинээр ажилд орсон 3 ажилтанд урьдчилсан зааварчилгаа, 42 ажилтанд ажлын байрны анхан шатны зааварчилгаа, 1798 ажилтанд өдөр тутмын зааварчилгаа, 317 ажилтанд сар бүрийн ээлжит зааварчилгаа, 235 ажилтанд ээлжит бус зааварчилгааг тус тус өгч ажилласан. Салбарын алба, хэсэг, дэд станцууд дээр аваар эсэргүүцэх дасгалыг 16 удаа зохион байгуулж 196 ажилтан, 2 удаагийн гал эсэргүүцэх дасгалд 48 ажилтан тус тус хамрагдсан.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн анхан шатны үзлэгийг давхардсан тоогоор 88 удаа хийж 134 зөрчил, II шатны үзлэгийг 31 удаа хийж 51 нэрийн зөрчил илрүүлж, устгах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. Ажилтнуудын эрүүл мэндийг дэмжих, мэргэжлээс шалтгаалах өвчлөл, бусад эмгэг өвчнийг эрт илрүүлэх, ажлын бүтээмжийг сайжруулах зорилгоор жил бүр хийгддэг эрүүл мэндийн үзлэгийг амжилттай зохион байгуулж, ажилтнуудаа бүрэн хамруулсан.


Салбарын хэмжээнд шинээр ажилд орсон болон зэрэг, групп ахих ажилтнуудаас ТАД, ААД-ийн ээлжит бус шалгалтыг тухай бүр авч ажилласан. Мөн салбарын хэмжээнд хийгдэж байгаа их болон урсгал засварын ажлуудад хөдөлмөрийн аюулгүй байдлын хяналт тавьж, зөрчлийг арилгуулах ажлыг хийсэн.

◀ АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР ▶

Техник зохион байгуулалтын арга хэмжээгээр 220/110/35/6 кВ-ын Эрдэнэт дэд станцын Т-1, Т-2 трансформаторын болон 110/35/10 кВ-ын Булган дэд станцын 110 кВ-ын Булган-А шугамын реле хамгаалалт автоматикийн байгууламжийг шинэчлэх, 220/110/35/6 кВ-ын Эрдэнэт дэд станцын холбооны болон ахлах диспетчерийн өрөөний засвар, 110 кВ-ын Тэлмэн цахилгаан дамжуулах агаарын шугамын 7000 ширхэг тусгаарлагч элемент солих ажил тус тус хийгдсэн.



нэвт цохигдсон элемент, утасны судал тасарсан гэмтлийг тус тус устгасан.



220/110/35/6 кВ-ын Эрдэнэт дэд станцын 220 кВ-ын 203 дугаар цахилгаан дамжуулах агаарын шугамын МТО, ГХ, 220 кВ-ын 203 дугаар агаарын шугамын бэлтгэл хамгаалалт, 110 кВ-ын Гок-Г, Д цахилгаан дамжуулах агаарын шугамын тулгуур будах, 35 кВ-ын Город-А ТТ, ШуС, 35 кВ-ын Город-А цахилгаан дамжуулах агаарын шугамын реле хамгаалалт автоматик, 110/35/6 кВ-ын Мөрөн дэд станцын ХТ-1 хүчдэлийн трансформатор, 35 кВ-ын ХТ-2 хүчдэлийн трансформатор, 110 кВ-ын ШДХ-ын реле хамгаалалт автоматик, 110/35/10 кВ-ын Баянтээг дэд станцын Т-1 трансформаторын реле хамгаалалт автоматик, 110/35/10 кВ-ын Булган дэд станцын Т-1 трансформаторын реле хамгаалалт автоматик, Булган-А цахилгаан дамжуулах агаарын шугамын элемент солих, угаах, 110/35/10 кВ-ын Арвайхээр дэд станцын 10 кВ-ын I секцийн тосон таслуурууд, хүчдэлийн трансформатор, 10 кВ-ын I секц тосон таслууруудын реле хамгаалалт автоматик, 110 кВ-ын Баянхонгор цахилгаан дамжуулах агаарын шугам, 110/35/10 кВ-ын Хархорин дэд станцын 35 кВ-ын ШинС, 10 кВ-ын

реактор-1-ийн реле хамгаалалт автоматик, 110/35/10 кВ-ын Сансар дэд станцын 35 кВ-ын ШинС-уудад их засварын ажлыг тус тус гүйцэтгэсэн.

110 кВ-ын Хялганат-А цахилгаан дамжуулах агаарын шугамын ШуС, ТойС, ГТ, реле хамгаалалт автоматик, 110/35/10 кВ-ын Арвайхээр дэд станцын 10 кВ-ын реактор-1-ийн реле хамгаалалт автоматик, Т-1 трансформатор, түүний холболтууд, 35 кВ-ын ХТ-1 хүчдэлийн трансформаторын реле хамгаалалт автоматик, 110/35/10 кВ-ын Баянтээг дэд станцын Т-1 трансформаторын реле хамгаалалт автоматик, 35 кВ-ын ХТ-1 хүчдэлийн трансформаторын реле хамгаалалт автоматик, 110/35/6 кВ-ын Мөрөн дэд станцын 6 кВ-ын ДХТ-2 дотоод хэрэгцээний трансформатор, 110/35/10 кВ-ын Цэцэрлэг дэд станцын Т-1 трансформатор, 10 кВ-ын секцийн реле хамгаалалт автоматик, 110/35/10 кВ-ын Булган дэд станцын 110 кВ-ын ХТ-2 хүчдэлийн трансформаторын реле хамгаалалт автоматик, 110/35/10 кВ-ын Хархорин дэд станцын 10 кВ-ын I секцийн тоноглолууд, реле хамгаалалт автоматик,

10 кВ-ын секцийн реле хамгаалалт автоматик, Т-1 трансформатор, реле хамгаалалт автоматикийн урсгал засварын ажлыг гүйцэтгэсэн.

220/110/35/6 кВ-ын Эрдэнэт дэд станцын 35 кВ-ын реактор-2-ын тосны шүүрэлтийг зогсоох, 6 кВ-ын Яч№7 ОРА метал гаргалгааны тулгуур дээр кабелийн муфт буудсан, 220 кВ-ын 203, 204 дүгээр цахилгаан дамжуулах агаарын шугамын утасны судал тасарсан, 110 кВ-ын Хялганат-А цахилгаан дамжуулах агаарын шугамын тулгуур №32-ын А фазын элемент нэвт цохигдсон, тулгуур №38-ын В фазын 1 элемент нэвт цохигдсон, 110/35/10 кВ-ын Булган дэд станцын 110/35 кВ-ын Ил хуваарилах байгууламжийн гэрэлтүүлгийн кабель, 110/35/6 кВ-ын Мөрөн цахилгаан дамжуулах агаарын шугамын

220/110/35/6 кВ-ын Эрдэнэт дэд станцын 110 кВ-ын ГОК-АБ, ГД, 35 кВ-ын Блок-1,2,3 цахилгаан дамжуулах агаарын шугам, 110 кВ-ын Арвайхээр, 110 кВ-ын Баянхонгор, 110 кВ-ын Булган-Мөрөн цахилгаан шугамуудад ээлжит үзлэг, 110 кВ-ын Хархорин-А,Б шугамд инженер техникийн ажилтнуудын үзлэг тус тус хийж, салбарын хэмжээнд шугам, тоноглолын найдвартай ажиллагааг хангаж ажилласан.

Хангайн бүсийн салбарын сургалт, бүтээмжийн инженер В.Адъяа



ЗҮҮН-ӨМНӨД БҮСИЙН САЛБАР

ХАБЗА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

Салбарын хэмжээнд урьдчилсан зааварчилгаанд хоёр ажилтан, сарын давтан зааварчилгаанд 286 ажилтан, ээлжит бус зааварчилгаанд 648 ажилтан, өдөр тутмын давтан зааварчилгаанд 3768 ажилтан давхардсан тоогоор хамрагдсан.

Аваар эсэргүүцэх дасгал 7 удаа зохион байгуулж 65 ажилтан, галын аюулаас урьдчилан сэргийлэх дасгалыг 46 удаа зохион байгуулж 125 ажилтан, анхны тусламж үзүүлэх дасгалыг 22 удаа зохион байгуулж 10 ажилтан давхардсан тоогоор хамрагдаж, аюул ослоос урьдчилан сэргийлж ажилласан. Засвар хийгдэж байгаа ажлын байруудад нарядын системийн

мөрдөлт, зааварчилгаа өгөлт, ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн ашиглалт, ажлын байранд хэрэглэж байгаа байдалд хяналт тавьж ажилласан. Салбарын хэмжээнд дэд станцуудын цахилгаан тоног төхөөрөмжүүдэд болон цахилгаан дамжуулах агаарын шугамуудад хийгдэх төлөвлөгөөт их ба урсгал засвар, гэмтэл устгалтын ажлаар аюулгүй ажиллагааны нарыдаар 121 ажил, шийдвэрээр 77 ажил хийгдсэн. 110 кВ-ын Хот цахилгаан дамжуулах агаарын шугамын тулгуур № 5,6 солих, 110 кВ-ын Төв цахилгаан дамжуулах агаарын шугамын аянгын троссыг шилэн кабель бүхий аянгын троссоор солих,

110 кВ-ын Төв-А,Б цахилгаан дамжуулах агаарын шугамын анкер будах ажлуудад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн инженерүүд биечлэн хяналт тавьж ажилласан.

Ажлын байр өөрчлөгдсөн болон анхны шалгалтыг гурван ажилтнаас авч, мэргэжлийн зэрэг, аюулгүй ажиллагааны групп олгож, салбарын даргын тушаалаар холбогдох албан тушаалд нь ажиллуулж байна. Эрчим хүчний яам, компаниас ирсэн мэдээлэл даалгавруудыг бүх алба, хэсэг, дэд станцуудад хүргүүлж, ажилтнуудад танилцуулах, ээлжит бус зааварчилгаа өгөх,

аюулгүй ажиллагааг хангаж ажиллахыг үүрэг болгон ажилласан. 2020 оны 08 дугаар сарын 12-ны өдөр 110/10 кВ-ын Баянмөнх дэд станцад Т-1 110 кВ-ын тосон таслуур тасарсан, 2020 оны 08 дугаар сарын 12-ны өдөр 110/35/10 кВ Айраг дэд станцын Т-1 10 кВ-ын тосон таслуур тасарсан тасралтын дүгнэлт, зөрчлийн актыг гаргаж, холбогдох хэлтэс, ажилтнуудад танилцуулсан.

Салбарын харьяа дэд станцуудын хашаа, Ил хуваарилах байгууламжид ургасан зэрлэг өвс, ургамлыг хадаж, галын аюулгүй байдлаас урьдчилан сэргийлж ажилласан.

АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

2020 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн байдлаар хийгдсэн засварын ажлын мэдээ

Ажлын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
Их засвар	17	13	76%
ТЗБАХ	27	24	88%
Урсгал засвар	149	141	95%
Ашиглалтын түвшин дээшлүүлэх	222	276	124%
Аянгын улирлын	95	90	95%
Гэмтэл устгах		56	

Засварын ажил

Их засварын ажлаар 220/110/35 кВ-ын Багануур дэд станц зөөврийн тос цэвэрлэх төхөөрөмж засварлах, Төв-А,Б 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын анкер будах их засварын ажлуудыг гүйцэтгэж, ашиглалтын түвшинг дээшлүүлсэн.

220/110/35 кВ-ын Чойр дэд станцын ДХТ-1,2 дотоод хэрэгцээний трансформатор, 110/10 кВ-ын Замын-Үүд дэд станцын



ДХТ-1 дотоод хэрэгцээний трансформатор, 110/35/6 кВ-ын Өндөрхаан дэд станц ДХТ-1 дотоод хэрэгцээний трансформаторын хүчин чадал нэмэгдүүлэх, 110/35/6 кВ-ын Бор-Өндөр дэд станцын Ячейк №5,4,0, 110/35/10 кВ-ын Айраг дэд станцын Ячейк №3,16,20-ын 10 кВ-ын гүйдлийн трансформаторуудыг нарийвчлал өндөртэй

гүйдлийн трансформатораар солих, Айраг дэд станцын Ячейк №3 10 кВ-ын, 110/35/6 кВ-ын Өндөрхаан дэд станцын Ячейк №20 6 кВ-ын тосон таслууруудыг вакуум таслуур солиж, реле хамгаалалт автоматикийг шинэчлэх, Хот-А,Б 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын цууралттай тулгуур №5,6-г шинэчлэх, Төв-А,Б 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын аянгын троссыг шилэн кабель бүхий троссоор солих, салбарын контор болон 110/10 кВ-ын Төв дэд станцын хооронд шилэн кабель татаж дотуур холбоо, интернет холбох зэрэг томоохон ажлуудыг ТЗБАХ-ээр хийж гүйцэтгэсэн.

Урсгал засвараар Бор-Өндөр дэд станцын тоноглолын засвар, Багануур дэд станц 209, 210 дугаар агаарын шугамын реле хамгаалалт автоматикийг шалгаж ажилд оруулах, Хот-А,Б 110 кВ-ын ТТ, Бор-Өндөр-Өндөрхаан 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, Замын-Үүд дэд станцын 10 кВ-ын хаалттай хуваарилах байгууламж зэрэг 22 ажлыг 4,1 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн.

Ашиглалтын түвшин үзлэг үйлчилгээний 61 ажлыг 3.5 сая, гэмтэл устгалын 15 ажлыг 1,5 сая төгрөгөөр тус тус хийсэн.




ЦАГ ҮЕИЙН АЖЛААР

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдал зарласантай холбогдуулан сургалтыг салбарын телеграмын “ЗӨБС СУРГАЛТ” хаягаар дамжуулан цахим хэлбэрээр тогтмол зохион байгуулж байна. Салбарын ажилтнуудыг коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор 2020 оны 06, 07 дугаар саруудад Эрүүл мэндийн яамнаас гаргаж буй 25 төрлийн видео зөвлөмж, 25 төрлийн зурагт хуудас салбарын телеграмын “ЗӨБС СУРГАЛТ” хаягт байршуулана. 12 төрлийн сэдвээр 96 цагийн “Анхны тусламж”-ийн зайн сургалт зохион байгуулав. Сургалтад давхардсан тоогоор 800 ажилтан хамрагдсан.

САЛБАРЫН “АЖЛЫН БАЙРНЫ СОЁЛ-5С” АЯНЫ ЯВЦ


Салбарын хэмжээнд “Ажлын байрны соёл-5С” аяныг 2020 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд зарласан. Аяны хүрээнд хэсэг, алба, дэд станцуудад 40 нэр төрлийн ажил хийгдсэн. 220/110/35/6 кВ-ын Чойр дэд станц, 110/35/6 кВ-ын Бор-Өндөр дэд станц, 110/10 кВ-ын Замын-Үүд дэд станцууд аяндаа идэвхтэй оролцож байна.



110/35/6 кВ-ын Бор-Өндөр дэд станцын 110 кВ-ын ил хуваарилах байгууламжид байрлах Өндөрхаан 110 кВ-ын ЭТ-ын даралт хэмжигч манометр наранд хэт халсны улмаас буруу заах тохиолдол гардаг байсаныг хаалт байрлуулан ашиглалтыг сайжруулсан.



110/10 кВ-ын Замын-Үүд дэд станцын диспетчерийн ажлын байрны гадна талбайд саравч угсарч байрлуулсан.



110/10кВ-ын Замын-Үүд дэд станцын агуулахыг доторлож тавиур угсарч эд зүйлсийг эмх цэгцтэй байрлуулсан байдал.

ОЛОН НИЙТИЙН АЖЛУУД

1. Үндэсний сурын холимог багийн улсын аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцон түрүүлж, алтан медаль хүртсэн жолооч Г.Ариунболд, жолооч А.Мөнхтогтох нар Багануур дүүргийн 40 жилийн ойн медаль, мөн Г.Ариунболд иргэдийн төлөөлөгчдийн хурлын “Жуух бичиг”-ээр шагнууллаа.



2. ГБТХ-ийн инженер Д.Баяржаргал Багануур дүүргийн “Баярын бичиг”, Монголын эмэгтэйчүүдийн холбооны “Дурсгалын тэмдэг”-ээр, зураг төсвийн инженер Б.Бадралмаа тус холбооны “Хүндэт тэмдэг”-ээр тус тус шагнууллаа.



ГОВИЙН БҮСИЙН САЛБАР

◀ ХАБЗА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ ▶

Салбарын хэмжээнд 2020 оны 07, 08 дугаар сард нарыдаар 31 ажил, шийдвэрээр 84 ажил хийгдсэн. Наряд, шийдвэрээр ажил гүйцэтгэхэд ажлын аюулгүй байдлыг хариуцагчид болон бригадын бүрэлдэхүүнд онцгой анхааран, шат шатны зааварчилгааг чанартай өгч, хяналт тавьж ажилласан.

Салбарын хэмжээнд 11 удаагийн дасгал зохион байгуулж 113 ажилтан хамруулж, сарын давтан зааварчилгааг 147 ажилтан, тухайлсан зааварчилгааг 698 ажилтан,

ээлжит бус зааварчилгааг 412 ажилтанд тус тус өгсөн. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн анхан шатны үзлэгийг 525 удаа хийж 26 зөрчил, II шатны үзлэгийг 23 удаа хийж 33 зөрчил илрүүлэн устгаж, аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авч ажилласан. Галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэгийг 161 удаа хийж илэрсэн зөрчлүүдийг устгах үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үндэсний их баяр наадмын өдрүүдээр

шугам, тоноглолын найдвартай ажиллагааг ханган ажиллах тухай Говийн бүсийн салбарын даргын 2020 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн А/20 дугаар тушаалын дагуу шугам тоноглолын найдвартай ажиллагааг хангах хариуцлагатай жижүүр томилогдон ажиллав. 2020 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн 20:00 цагаас 07 дугаар сарын 16-ны өдрийн 08:00 цаг хүртэл салбарын инженер техникийн найман ажилтан хариуцлагатай жижүүр инженерээр батлагдсан графикайн

дагуу 07 дугаар сарын 11-ний өдрийн 08:00 цагаас 12-ны өдрийн 20:00 цаг хүртэл 220/110/35 кВ-ын Мандал дэд станцад хуваарт цагтаа байрлан, 07 дугаар сарын 13, 14, 15-ны өдрүүдэд гэрийн жижүүрээр ажиллан, салбарын харьяа дэд станцуудын горим схемийн байдалтай танилцан хариуцлагатай жижүүрийн журнал хөтөлж, компанийн хариуцлагатай жижүүрт мэдээ өгч ажилласан.

◀ АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР ▶

2020 оны 07 дугаар сарын 12-ны өдрийн 02:39 цагт 209 дүгээр агаарын шугам 33-I-р тасарч АПВ амжилттай ажиллах үед Тавантолгой дэд станцад 35 кВ-ын Уурхай агаарын шугамын вакуум таслуур, Манлай агаарын шугамын элегаз таслуур, Даланзадгад дэд станцад 10 кВ-ын Ханхонгор, Полигон агаарын шугамын вакуум таслуур, Мандалговь дэд станцад 35 кВ-ын Төв агаарын шугамын вакуум таслуур, Олгойнговь агаарын шугамын элегаз таслуур АЧР-р тасарч, эргээд залгахад хэвийн залгагдсан.

Тавантолгой дэд станцад ЭСБА захиалга №01, наряд №97-р аваарын процесс бүртгэх төхөөрөмж шинээр суурилуулах, монтаж хийж тохируулах ажлын хүрээнд 110/35 кВ-ын фидерүүдийн гүйдлийн хэлхээний кабелиуд татсан. Таслуурын төлөв, гүйдлийн хэлхээнд нийт 4200 метр кабель татаж холболт хийх бэлтгэл ажлыг хангав. 220 кВ-ын гарсан шугамууд, 110 кВ-ын бэлтгэлд байгаа тоноглолуудыг гүйдлийн хэлхээний холболт хийж монтажлав. /АУРА/

2020 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн 10:52-19:15 цагийн хооронд, 07 дугаар сарын 11-ний өдрийн 11:50-20:00 цагийн, 07 дугаар сарын 12-ны өдрийн 10:10-22:40 цагийн хооронд, 07 дугаар сарын 13-ны өдрийн 08:35-02:10 цагийн хооронд, 07 дугаар сарын 14-ны өдрийн 08:30-13:50 цагийн хооронд, 07 дугаар сарын 15-ны өдрийн 09:15-20:37 цагийн хооронд Тавантолгой, Оюутолгой дэд станцуудад ТВЕА захиалга №51, Шийдвэр №227, 228, 229, 230, 231, 232 Өргөтгөлийн ажлыг хүлээн авах комиссын үүрэг даалгаврын дагуу дутуу ажлыг төлөвлөгөөний дагуу 220 кВ-ын хуурай салгуурын хоригийн тэжээлийг удирдлагын хэлхээнээс салгаж, тусдаа тэжээлтэй болгох ажлын хүрээнд: 213, 214, 217, 218 дугаар агаарын шугамын хуурай салгуурын ГХ хоригийн тэжээлийг таслуурын удирдлагын тэжээлээс тусдаа болгож монтаж хийв. 217, 218 дугаар агаарын шугамын постны тохиргоо хийж алдаатай монтажийг засаж хэвийн болгосон

- 220 кВ-ын Ил хуваарилах байгууламж, холболтын хайрцаг, гүйдлийн трансформатор, хуурай салгууруудын удирдлагын шкафд битүүмж сайжруулах ажил хийв. 2. 220 кВ-ын шин холбогч таслуур, АТ-2, 219, 220, 221, 222 агаарын шугамын хуурай салгуурын ГХ хоригийн тэжээлийг удирдлагын тэжээлээс тусдаа болгож монтаж хийсэн

- 223, 224, 215, 216 дугаар агаарын шугам, 220 кВ-ын шин холбогч таслуур, АТ-1-ийн хуурай салгуурын ГХ хоригийн тэжээлийг удирдлагын тэжээлээс тусдаа болгож монтаж хийв. 215, 216 дугаар агаарын шугамын постны тохиргоог хийж алдаатай монтаж засав. SVC-1,2-н реле хамгаалалтын панелийн 3,5 гармонекийн мнемо схемийн байршил өөрчилсөн
- АТ-2 35 кВ-ын ШинС-1 төлөв заахгүй, 222, 221 дүгээр агаарын шугам ШинС-1, ШинС-2 удирдлагаар тасрахгүй, 218 дугаар агаарын шугамын таслуур төлөв SEL реле дээр заахгүй, 220 дугаар агаарын шугамын таслуур тасрахгүй байсан гэмтлүүдийг устгасан.
- 220/110 кВ-ын шкафуудын битүүмжлэлийг сайжруулж хийсэн.

Реле хамгаалалт, автоматик, хэмжилт туршилтын албаны бригад 110/35/10 кВ-ын Тавантолгой дэд станцыг 220 кВ-ын хүчдэлийн түвшинд залгах ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:

- 215, 216 дугаар агаарын шугамын үндсэн бэлтгэл хамгаалалтуудын тавил тохиргоог ДҮТ ХХК-аас ирүүлсэн албан бичгийн дагуу өөрчилж, ажиллагааг шалган залгахад бэлэн болгосон.
- АТ-1, 2 220 кВ-ын ДЗШ-н не-балансын гүйдлийг ачаалал дор хэмжиж АТ-1, 2-ын үндсэн хамгаалалтад гүйдлийн ялгавар үүсээгүй тул ажилд оруулсан. 220 кВ-ын ДЗШ-н ZONE-1 0,01 А ялгавар үүссэн тул программын тохиргоо хийж не-балансын гүйдлийг устгасан. АТ-1, 2 болон 216 дугаар агаарын шугамын үндсэн болон бэлтгэл хамгаалалтын чадлын вектор диаграмм үзэж шалгахад алдаагүй хэвийн байсан. АТ-1, 2-ын чадлын чиглэлүүд буруу зааж байсныг зассан.
- 215, 216 дугаар агаарын шугамын фазын дарааллыг шалгахад хэвийн байв. Фазын дарааллыг Мандал дэд станц талд А, В, С фазуудаа ээлж дарааллуулан зөөврийн газардуулгаар газардуулж, Тавантолгой дэд станц талд мегаомметрээр хэмжиж шалгасан.
- 220/110 кВ-ын хүчдэлийн трансформатор-1, 2-ийн 100В-ын фазын дараалал шалгахад хэвийн таарч байв.
- 220 кВ-ын хүчдэлийн трансформатор-2-ийн А фазын хоёрдогчийн xd, ad, 1a, 1x холболтуудыг буруу холбосон байсныг засаж хэвийн болгосон.

- 35 кВ-ын СВК-1, СВК-2 удирдлага хяналтын панелиудад хүчдэлийн хэлхээний холболт буруу байсныг засаж гэмтлийг устгасан.
- 215 дугаар агаарын шугамын үндсэн болон бэлтгэл хамгаалалтыг ДҮТ ХХК-аас ирүүлсэн албан бичгийн дагуу тохируулж гүйдэл, хүчдэл шахаж шалгахад ажиллагаа хэвийн байсан.
- 215 дугаар агаарын шугамын холболтын филтерийг авч 216 дугаар агаарын шугамд сольж холболтын схемийн дагуу холбов.
- АТ-1 220/110/35 кВ-ын тоолуур, хэмжүүр, бэлтгэл хамгаалалтын гүйдлийн хэлхээ, АТ-2 220/110/35 кВ-ын тоолуур, хэмжүүр, бэлтгэл хамгаалалтын гүйдлийн хэлхээний полярностиг солив.
- 215 дугаар агаарын шугамын үндсэн болон бэлтгэл хамгаалалтын хэмжүүр тоолуурын хэлхээнд вектор диаграммын хэмжилт хийхэд хэвийн байна.
- 217, 218 дугаар агаарын шугамын SEL-311С реле дүт ХХК-аас ирсэн тавилын албан бичгийн дагуу тавил тохиргоог хийсэн.
- 218 дугаар агаарын шугамын хамгаалалт гүйдэл шахаж таслуурын харилцан үйлчлэл шалгахад ажиллагаа хэвийн, үндсэн хамгаалалт болон АПВ-г ажлаас гаргаж бэлтгэл хамгаалалтын хурдасгах хэлхээг ажилд оруулсан.
- СВК-1, 2-т гармонекийн хэмжилтийг Оюутолгой уурхайн инженер техникийн ажилчидтай хамтран хийхэд Н-3 нь 0,1%, Н-5 нь 4.6%-тай буюу зөвшөөрөгдөх хэмжээнд байна.

220/110/35 кВ-ын Оюутолгой дэд станцыг 220 кВ-ын хүчдэлд залгах ажлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:

- 220/110/35 кВ-ын панель хооронд хүчдэлийн хэлхээний шин холболт хийгдээгүй байсныг шинээр холболт хийсэн.
- АТ-1 автотрансформаторын хуучин панелийн схемийг шинэ тоноглолуудтай уялдуулан монтаж холболтыг хийж шалгасан. ДҮТ ХХК-аас ирсэн албан бичгийн дагуу тавил тохиргоог хийж ажиллагааг шалгахад хэвийн байв.
- 220 кВ-ын ДЗШ-ын схемийг засаж ажиллагааг хэвийн болгосон. Шинийн хамгаалалтаас гарсан шугам, автотрансформатор руу таслах гаралт тус бүрийг накладаар дайруулан

монтажилсан. Гарсан гаргалгаануудаас УРОВ эхлүүлэх зөвшөөрөл шинийн хамгаалалт руу зөв ирж байгааг нэг бүрчлэн шалгасан. Шинийн хамгаалалтын SEL-487В реленд тавил тохиргоо хийсэн.

- 35 кВ-ын Реактор-2 гүйдлийн трансформаторын шкафант хоёрдугаар ороомгийн С фаз, гуравдугаар ороомгийн N-тэй солигдсон байсныг засаж, ажиллагааг хэвийн болгов.
- 110 кВ-ын ХТ-2 хүчдэлийн трансформаторын В фазын дээд холболтонд хоёрдогч хэлхээний холболт монтаж буруу байсныг засаж хэвийн болгосон.
- 35 кВ-ын ХТ-2 хүчдэлийн трансформаторын холболт монтажийг шалгахад хэвийн байна. А, В, С фазын хүчдэлүүд дутуу зааж байсан тул гүйцэтгэгч компаниар засварлуулах шаардлага тавьсан.
- 35 кВ-ын ХТ-1 хүчдэлийн трансформаторт үзлэг хийж гадна ХТ-н шкафант В, С фаз солигдсон байсныг хэвийн болгож ачаалал дор хэмжилт хийхэд хэвийн байв.
- 217, 218 дугаар агаарын шугам, 220 кВ-ын шин холбогч таслуур, 110 кВ-ын секц холбогч таслуур, 35 кВ-ын секц холбогч таслуур, 35 кВ-ын Реактор-2, ДХТ-2 35 кВ-ын, 35 кВ-ын Ханбогд агаарын шугам, 35 кВ-ын Оюу-А, Б агаарын шугам, 35 кВ-ын НТ-1, 2, АТ-2 автотрансформаторын үндсэн болон бэлтгэл хамгаалалтуудад ДҮТ ХХК-аас ирүүлсэн тавилын албан бичгийн дагуу тавил тохиргоог хийж ажиллагааг шалгав.
- 35 кВ-ын ХТ-1, 2-ын задгай гурвалжингийн холболтыг хийж, шинээр автомат суурилуулан ашиглах үед анхаарах санамжийг боловсруулсан.
- 110 кВ-ын хүчдэлийн трансформаторын холболт буруу хийгдсэн байсныг шинээр хийж алдааг зассан.

Говийн бүсийн салбарын хүний
нөөцийн мэргэжилтэн Ц.Ганнагт



ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ ТӨХК-НИЙ 2020 ОНД ХИЙГДЭЖ БАЙГАА ТОМООХОН АЖЛУУД

1. ТАВАНТОЛГОЙ ХХК-ИЙН “САЙЖРУУЛСАН ШАХМАЛ ТҮЛШНИЙ ҮЙЛДВЭР”-ИЙН ЦАХИЛГААН ХАНГАМЖИЙН ЗОРИУЛАЛТТАЙ 110 КВ-ЫН ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ АГААРЫН ШУГАМ БОЛОН 110/10 КВ-ЫН ДЭД СТАНЦЫН БАРИЛГА УГСРАЛТЫН АЖИЛ

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 35 дугаар тогтоолоор Сайжруулсан шахмал түлшний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор Нийслэлийн зүүн бүсэд шинээр үйлдвэр байгуулах шийдвэр гарсан.

Энэхүү шийдвэрийг үндэслэн Эрчим хүчний сайдын 2020 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн а/938 тоот албан бичгээр Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт баригдах Тавантолгой ХХК-ийн “Сайжруулсан шахмал түлшний үйлдвэр”-ийн цахилгаан хангамжийн зориулалттай 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам болон 110 кВ-ын дэд станцын барилга угсралтын ажлыг гүйцэтгэх үүрэг чиглэлийг манай компанид өгсөн.

- Ажлын эзлэхүүн
- 110 кВ-ын 16 ширхэг анкер, 11 ширхэг завсарын төмөр бетон тулгуур бүхий 5,695 км урттай хоёр хэлхээ цахилгаан дамжуулах агаарын шугам барих, (Утас-АС120/19, тросс-OPGW-42)
 - 110/10 кВ-ын Улаанхуаран дэд станцаас буусан 2х10МВА хүчин чадалтай хоёр

ширхэг хүчний трансформаторт их засварын ажил гүйцэтгэн 110 кВ-ын дэд станцад суурилуулах, 110 кВ-ын хоёр систем шин бүхий ил хуваарилах байгууламжийг иж бүрэн барьж байгуулах.

Манай компани 110 кВ-ын хоёр хэлхээ цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын 110/10кВ-ын хүчний трансформатор хүртэлх болон реле хамгаалалт автоматик, удирдлага, төв дохиоллын угсралтын ажлыг гүйцэтгэж байгаа ба дотоод нөөц бололцоогоо ашиглан батлагдсан төсөвт зардлаас хоёр дахин бага өртгөөр гүйцэтгэж байна.

Цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын барилга угсралтын ажлыг Улаанбаатар салбар хариуцан гүйцэтгэсэн. Уг ажлын хэсгийн даргаар компанийн Тэргүүн дэд захирал бөгөөд ерөнхий инженер Б.Дашдаваа, гишүүдэд Улаанбаатар салбарын дарга Ч.Мөнхпүрэв, ерөнхий инженер Д.Жаавай болон бүх албадын дарга нар удирдлага зохион байгуулалтыг хариуцан ажилласан. Дэд



110/10 кВ-ын Илч баян дэд станцын угсралтын ажлын дараа

станцын засвар угсралтын ажлыг Засварын албаны ахлах бөгөөд засварын инженер С.Ариунбат, шугамын угсралтын ажлыг шугамын засварын инженер Б.Ганхуяг, реле хамгаалалтын монтажийн ажлыг Реле хамгаалалт, автоматик, хэмжилт туршилтын албаны ахлах бөгөөд реле хамгаалалт, автоматикийн инженер Д.Өлзийсайхан нараар ахлуулсан 90 хүний бүрэлдэхүүнтэй, 10 гаруй машин механизмтай бригад 2020 оны 08 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн

ажилласан. 2020 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн байдлаар дэд станцын анхдагч болон хоёрдогч хэлхээний угсралтын ажил, түүнчлэн туршилт тохируулгын ажлыг төлөвлөсөн хугацаанаас өмнө дуусгаж, 2020 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр техникийн комисс ажиллаж цахилгаан дамжуулах агаарын шугам болон дэд станцын тоноглолыг хүчдэл дор амжилттай залгаснаар Тавантолгой шахмал түлшний ажил бүрэн дууслаа.

2. ЭРДЭНЭТ ДЭД СТАНЦЫН 200 МВА АТ-2-Н ГЭМТЛИЙГ УСТГАЖ, АЖИЛЛАГААНД ЗАЛГАХ АЖИЛ

Украин Улсын ЗТЗ-СЕРВИС компанийн мэргэжилтнүүд, Техникийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн техникийн судалгааны инженер А.Эрдэнэбилэг, Төсөл хөтөлбөрийн хэлтэс, Хангайн бүсийн салбар хамтран Эрдэнэт дэд станцын 200 МВА Автотрансформатор-2-ийн гэмтлийг устгаж, Эрдэнэт хот руу тээвэрлэж, өвлийн их ачааллаас өмнө ажилд залгахад шамдан ажиллаж байна. Уг автотрансформатор 2018 онд гэмтэж, Украин улсын мэргэжилтнүүдтэй хамтарч 2019 онд гэмтлийг тодорхойлсон. АТ-2-ийн РПН-ийн салаалгын ороомогт ороодос хоорондын богино залгаа болох үед хөндийрүүлэг гэмтсэн байсныг тусгаарлагчийг хүчитгэх, хийцийг өөрчлөх арга хэмжээ авч, гэмтсэн хэсгийг сольж шинэчилж зассан.




АТ-2-ийн гэмтлийг тодорхойлж байгаа нь

Тус компанийн инженерүүд Украин Улсын мэргэжилтнүүдтэй хамтарч 200 МВА автотрансформаторын гэмтлийг Монгол Улсад анх удаа засварлах ажлыг амжилттай гүйцэтгэж, ашиглалтад хүлээлгэн өгөхөөр шамдан ажиллаж байна.

4. 257, 258 ДУГААР ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ АГААРЫН ШУГАМЫН ХИЛИЙН ЗУРВАС ДАХЬ ТУЛГУУРЫН ЭЗЭМШЛИЙН ЗААГ ТОДОРХОЙЛОХ, ГЭМТЭЛ УСТГАХ АЖИЛ

257, 258 дугаар агаарын шугамыг Дархан-Сэлэнгийн цахилгаан шугам сүлжээний газрын харьяа 220/110/35 кВ-ын Дархан дэд станц дээр 1976 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 00 цагт хүчдэл өгч, анх удаа Монгол Улсын эрчим хүчний системийг ОХУ-ын эрчим хүчний системтэй өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугамаар зэрэгцээ ажиллаж эхэлсэн, 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг ашиглалтад хүлээн авснаар Монгол Улсад 220 кВ-ын агаарын шугам, дэд станцын тоноглолын ашиглалт, засварын ажлыг хариуцсан инженер техникийн ажилтан бэлтгэгдэн ирсэн түүхтэй билээ. 2015 оноос хойш хоёр улсын хэмжээнд яригдаж эхэлсэн Монгол Улс – ОХУ холбосон 257, 258 дугаар агаарын шугамын торгон хилийн зурвас дахь төмөр тулгуур, утас, арматуруудын үзлэг, засварын ажлыг зохион байгуулан хамтран ажиллах зорилгын хүрээнд 2020



257, 258-р цахилгаан дамжуулах агаарын шугамын хилийн заагт байгаа тулгуурууд

онд хоёр улсын хилийн тусгай алба, хилчидтэй хамтран ойрын жилүүдэд хийгдээгүй засвар үйлчилгээ, тулгууруудын номер дугаар, зааг тогтоох ажлыг 2020 оны 09 дүгээр сарын 09-ны өдрөөс 09 дүгээр сарын 10-ны өдрүүдийн хооронд хийж гүйцэтгэлээ. Цаашид ашиглалтын зааг, тулгуурын дугаарлалтыг шинэчлэх ажил зохион байгууллахаар ОХУ, ДҮТ ХХК-тай тохиролцсон.

3. 110/10 КВ-ЫН БАЯНТЭЭГ ДЭД СТАНЦАД 10 КВ КОМПЕНСАТОР СУУРИЛУУЛАХ

Өсөн нэмэгдэж буй ачаалал, 110 кВ-ын хэт урт цахилгаан дамжуулах агаарын шугамаас хамаарч Хархорин, Арвайхээр, Баянтээг, Баянхонгор чиглэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам болон дэд станцуудын хүчдэл нэгдсэн сүлжээний дүрэмд заагдсан хэмжээнд барьж ажиллах техникийн боломжгүй байдал үүссэн тул Үйлдвэрлэл техникийн зөвлөлийн хурлаас горимын тооцоо судалгааны үндсэн дээр 110/35/10 кВ-ын Сайншанд дэд станцын 3 МВар-ын хүчин чадалтай компенсаторыг 110/35/10 кВ-ын Баянтээг дэд станцад шилжүүлэн суурилуулах шийдвэр гаргасан.

Уг компенсаторын угсралтыг 2020 оны 09 дүгээр сарын 08-ны өдрөөс 09 дүгээр сарын 10-ны өдрүүдийн хооронд Хангайн бүсийн салбарын Засварын инженер Э.Баянхангайгаар удирдуулсан найман хүний бүрэлдэхүүнтэй бригад угсран суурилуулж ажиллагаанд амжилттай залгасан.

- Баянтээг д/ст шинээр суурилуулсан 3.3 МВар-н компенсаторыг туршилтын хүчдэлд залгахад хүчдэл.

- Хархорин д/ст $U=111,1/36,5/10,6$ кВ-с $U=111/36,8/10,7$ кВ,
- Арвайхээр д/ст $U=107,8/35,1/10,2$ кВ-с $U=109,6/35,7/10,4$ кВ,
- Баянтээг д/ст $U=34,5/9,6$ кВ-с $U=36,8/10,5$ кВ,
- Баянхонгор д/ст $U=103/35/5,9$ кВ-с $U=106/36/6,07$ кВ болсон.

Горим тооцооны инженерүүд тооцоог зөв гаргасны улмаас хүчдэлийн түвшинг тодорхой түвшинд нэмэгдүүлж чадсан нь компанийн хэмжээний томоохон ажлуудыг нэг болсон.



Баянтээг дэд станцад 10 кВ-ын компенсатор суурилуулсан байдал

5. 205, 206 ДУГААР ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ АГААРЫН ШУГАМЫН АЯНГЫН ТРОССЫГ ШИЛЭН КАБЕЛЬ БҮХИЙ АЯНГЫН ТРОССООР СОЛИХ АЖИЛ

205, 206 дугаар цахилгаан дамжуулах агаарын шугамын аянгийн троссыг шилэн кабель бүхий аянгийн троссоор сольсноор мэдээлэл солилцох сувагчлалыг бүрдүүлэх, 205, 206 дугаар шугамын дагуу дифференциал хамгаалалтын мэдээллийн сувагчлалыг өөрийн шугамд бий болгох ач холбогдолтой ажил болсон.

Уг ажлын гүйцэтгэгч байгууллагаар Аркади ХХК шалгарч 2017 онд хийх төлөвлөгөөтэй байсан боловч 220 кВ-ын хоёр шугамыг зэрэг таслахад системийн хувьд

горимын хүндрэлтэй нөхцөл байдал үүсэх, түүнчлэн гүйцэтгэгч компанийн ажлын ур чадвараас хамаарч удаа дараа хойшлогдож байсан ажлыг Улаанбаатар салбарын шугамын засварын инженер Б.Ганхуягаар ахлуулсан 20 хүний бүрэлдэхүүнтэй бригад, гүйцэтгэгч Эрчим инженеринг ХХК-ийн цахилгааны инженер А.Нямбаяраар ахлуулсан 13 хүний бүрэлдэхүүнтэй бригад хамтран 2020 оны 08 дугаар сарын 12-ны өдрөөс 08 дугаар сарын 26-ны өдрийн хооронд бүрэн хийж амжилттай дуусгалаа.



Манай компанийн инженер техникийн ажилтнууд олон жил хойшлогдсон ажлыг хийж гүйцэтгэхийн зэрэгцээ өндөр ачаалалтай 220 кВ-ын хоёр шугамыг зэрэг таслах үед схемийн өөрчлөлтүүд болон параметруудийг тогтвортой барьж ажиллуулахад шаардлагатай горимын тооцоог хийж, диспетчерийн зохицуулалтыг амжилттай хийж дуусгалаа.

Агаарын шугам 205, 206-ын аянгийн тросс бүхий шилэн кабель татах ажил



6. 203, 204 ДҮГЭЭР ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ АГААРЫН ШУГАМЫН ИХ ЗАСВАРЫН АЖИЛ

Улаанбаатар салбарын Засварын албаны дарга В.Мөнхбат, шугамын засварын инженер Б.Ганхуягаар ахлуулсан 18 хүний бүрэлдэхүүнтэй бригад 220 кВ-ын 203, 204 дүгээр агаарын шугамын №131-136 тулгуурын хооронд АС-400/51 маркийн дамжуулагч утас, АС-70/72 маркийн аянгийн тросс солих их засварын ажлыг богино хугацаанд буюу 2020 оны 07 дугаар сарын 21-ний өдрөөс 2020 оны 07 дугаар сарын 31-ний өдрүүдэд хийж гүйцэтгэв. Дээрх ажлыг хийж гүйцэтгэхэд Улаанбаатар салбарын Засварын албаны хамт олны санаачилсан шинэ технологийг ашиглан Монгол Улсад анх удаа цахилгаан дамжуулах агаарын шугамын утас, троссыг газарт буулгалгүйгээр таталттай байхад нь 6 тоннын хоёр ширхэг гар тайл ашиглан тулгуур дээр нь амжилттай сольсон. Энэхүү ажлыг уламжлалт арга технологиор утас троссыг газарт буулгаж угсарсан тохиолдолд 20 хоногийн хугацаанд хоёр дахин их хүч, хөрөнгө зарцуулж хийх байсан бөгөөд дээрх технологийг туршсанаар хугацаа, зардлын нэлээдгүй хэмнэлт гаргаж, олон жил хойшлогдсон ажлыг амжилттай хийж чадлаа.



Тулгуур № 135-136 хооронд хуучин утсыг шинэ утастай холбож залгаа хийж байгаа байдал

7. ОЮУТОЛГОЙН ОРД ГАЗРЫН ЗАРИМ ХЭРЭГЛЭЭГ НЭГДСЭН СҮЛЖЭЭНЭЭС ХЭСЭГЧЛЭН ХАНГАХ 220/35 КВ-ЫН ОЮУ-А, Б ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ АГААРЫН ШУГАМЫГ АШИГЛАЛТАД ХҮЛЭЭН АВАХ АЖЛЫГ АМЖИЛТТАЙ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭЛЭЭ

2020/110/35 кВ-ын Оюутолгой дэд станцаас Оюутолгойн орд газрын хэрэглээг хэсэгчлэн хангах 35 кВ-ын Оюу-А агаарын шугамд хүчдэл өгөх техникийн комиссын дарга компанийн Тэргүүн дэд захирал бөгөөд ерөнхий инженер Б.Дашдаваа, Реле хамгаалалт, автоматик, хэмжилт туршилтын хэлтсийн дарга Н.Батбаяр, Шуурхай зохицуулалтын хэлтсийн дарга М.Өмөрбай, Говийн бүсийн салбарын ерөнхий инженер Б.Дамбийням, Техникийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн системийн тооцооны инженер А.Ананд, ДҮТ ХХК-ийн Мэдээллийн технологи холбооны албаны хяналт, мэдээллийн системийн тоног төхөөрөмжийн инженер Б.Батхүү, Цагаан Хорол ХХК-ийн дэд захирал Г.Энхбат, Цагаан Хорол ХХК-ийн ерөнхий инженер Бат-Ирээдүй, Эрчим инженеринг ХХК-ийн дэд захирал Н.Баярмагнай, Оюу Толгой ХХК-ийн дэд бүтцийн хэлтсийн инженерийн албаны дарга П.Найдан, Оюу Толгой ХХК-ийн өндөр хүчдэлийн албаны дарга З.Мөнхжаргал нарын бүрэлдэхүүнтэй техникийн комисс ажилласан. Техникийн комиссын шийдвэрээр 35 кВ-ын Оюу-А цахилгаан дамжуулах агаарын шугамд хүчдэл өгч, ачаалал дор 2020 оны 08 дугаар сарын 20-ны өдөр амжилттай залгаж, Оюутолгой уурхайн зарим хэрэглээг

цахилгаан эрчим хүчээр хангасан. 2020 оны 08 дугаар сарын 29-ний өдөр Эрчим хүчний яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Цахилгааны хэлтсийн дарга Д.Батзоригор ахлуулсан 19 гишүүний бүрэлдэхүүнтэй улсын комисс ажиллаж Оюутолгой уурхайн зарим хэрэглээг нэгдсэн системээс цахилгаан эрчим хүчээр тасралтгүй хангах шийдвэр гарсан. Монгол Улсын хамгийн том уул уурхайн орд газар болох Оюутолгойн уурхайд цахилгаан эрчим хүч нийлүүлж байгаа нь Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК болон Монгол Улсын эдийн засгийн үр өгөөж өгөх их ажлын зам тавигдаж байна.



Оюутолгой дэд станцад сэлгэн залгалт хийж байна

8. БНХАУ-ЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛЭЭР СОНГИНО-МАНДАЛ 330 КВ-ЫН ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ АГААРЫН ШУГАМ, ДЭД СТАНЦУУД БАРИХ ТӨСЛИЙН ХҮРЭЭНД 220/110/35/10 КВ-ЫН ТАВАНТОЛГОЙ ДЭД СТАНЦ, ОЮУТОЛГОЙ ДЭД СТАНЦЫГ 220 КВ-ЫН ХҮЧДЭЛД ЗАЛГАСАН

Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалын дагуу байгуулагдсан техникийн комисс Эрчим хүчний хөгжлийн төвийн Ерөнхий инженер Л.Батхүү, Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн Тэргүүн дэд захирал бөгөөд ерөнхий инженер Б.Дашдаваа, Реле хамгаалалт, автоматик, хэмжилт туршилтын хэлтсийн дарга Н.Батбаяр, Шуурхай зохицуулалтын хэлтсийн дарга М.Өмөрбай, Говийн бүсийн салбарын Ерөнхий инженер Б.Дамбийням, Говийн бүсийн салбарын Реле хамгаалалт, автоматик, хэмжилт

туршилтын албаны дарга Т.Цэнгэл, ДҮТ ХХК-ийн Мэдээллийн технологи холбооны албаны хяналт мэдээллийн системийн тоног төхөөрөмжийн инженер Б.Батхүү, ТВЕА ХХК-ийн төслийн инженер Б.Амар-Эрдэнэ, ЭХХТ-ийн ЗХХ ахлах инженер Ш.Шижирбат нарын бүрэлдэхүүнтэй 2020 оны 08 сарын 13-ний өдрөөс 2020 оны 08 дугаар сарын 20-ны өдрүүдэд Говийн бүсийн салбарт ажиллаж Тавантолгой, Оюутолгой дэд станцуудыг 220 кВ-ын хүчдэлд шилжүүлэх, ачаалал дор залгах шийдвэрүүдийг гаргасан.

• 2020 оны 08 дугаар сарын 14-ний өдөр 220/110/35/10 кВ-ын Тавантолгой дэд станцыг 220 кВ-ын Мандал дэд станцаас 215, 216 дугаар агаарын шугам болон 125 МВТ-ын автотрансформаторт хүчдэл

өгч, ачаалал дор амжилттай залгасан. 30МВА-ын SVC-д туршилт тохируулга хийж, ашиглалтад оруулсан.

• 2020 оны 08 дугаар сарын 18-ны өдөр 220/110/35 кВ-ын Оюутолгой дэд станцыг 220/110/35/10 кВ-ын Тавантолгой дэд станцаас 217, 218 дугаар агаарын шугамд болон 125 МВТ-ын автотрансформаторт хүчдэл өгч, ачаалал дор залгасан.

Уг ажлыг зохион байгуулахад шуурхай ажиллагааны болон инженер техникийн ажилчид мэдлэг чадвараа дайчлан сэлгэн залгалтын программыг богино хугацаанд боловсруулж, тоноглолд туршилт хийх ажлыг амжилттай гүйцэтгэж, дэд станцыг бүрэн ашиглалтад хүлээн авлаа.



Тавантолгой дэд станцыг 220 кВ хүчдэлийн түвшингээр залгасны дараа



ГБС-ын РХАХТА-ын хамт олон компанийн Тавантолгой дэд станцын Б.Мянганбуу ахлагчтай Ерөнхий инженерийн хамт шуурхай ажиллагааны ажилчид

Тавантолгой болон Оюутолгой дэд станцын 220 кВ-ын хүчдэлийн түвшингээр шилжүүлж залгахад шинээр залгагдах 220/110/35 кВ-ын бүх тоноглолуудын реле хамгаалалт, автоматик, хэмжүүр тоолуурын хэлхээг шалгаж, илэрсэн гэмтлийг устгаж, тавил тохиргоо хийх ажлыг Говийн бүсийн салбарын Реле хамгаалалт, автоматик, хэмжилт туршилтын албаны дарга Т.Цэнгэлээр ахлуулсан бригад богино хугацаанд гүйцэтгэсэн. 220/110/35 кВ-ын Оюутолгой дэд станцыг 220 кВ-ын хүчдэлийн

түвшинд холбох ажлын хүрээнд Засварын албаны дарга Ж.Шараваар ахлуулсан 10 хүний бүрэлдэхүүнтэй бригад 2020 оны 08 дугаар сарын 16-аас 08 дугаар сарын 21-ны өдрүүдэд АТ-ын 220/110/35 кВ талын холболт, 220/110 кВ-ын цэнэг шавхагчийн холболтыг хийж, 217, 218 дугаар агаарын шугамд үзлэг хийж, тулгуурын дугаар сэргээн газардуулгын эсэргүүцэл барихгүй 15 цэгт газардуулгын эсэргүүцэл бариулах ажил гүйцэтгэсэн.

9. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРААС ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА МЕГА ТӨСЛИЙН НЭГ ТАВАНТОЛГОЙ-ЗҮҮНБАЯНГИЙН ЧИГЛЭЛИЙН 414.6 КМ ТӨМӨР ЗАМ БАРИХ АЖЛЫН ХҮРЭЭНД 220/110/35 КВ-ЫН ТАВАНТОЛГОЙ, 220/22/35 КВ-ЫН ЦАГААНСУВРАГА ДЭД СТАНЦУУДЫН 35 КВ ХУВААРИЛАХ БАЙГУУЛАМЖИД ХИЙГДЭХ ӨРГӨТГӨЛИЙН АЖИЛ

Ажлын гүйцэтгэгчээр манай байгууллага шалгарч Тавантолгой дэд станцын 35 кВ-ын өргөтгөлийг Говийн бүсийн салбар, Цагаансувraga дэд станцын 35 кВ-ын өргөтгөлийн ажлыг Зүүн-Өмнөд бүсийн салбар хариуцаж ажиллаж байна. Тавантолгой дэд станцын 35 кВ-ын бүтээн байгуулалтын ажлыг Говийн бүсийн салбарын Засварын албаны дарга Ж.Шараваар удирдуулсан 21 хүний бүрэлдэхүүнтэй бригад гүйцэтгэж байна. Одоогийн байдлаар тоноглол угсрах газар шорооны ажил болон суурийн цутгалтын ажил дуусах шатандаа орж, анхдагч хэлхээний ажил дуусаж, хоёрдогч хэлхээний ажил эхэлж байна.

• Цагаансувraga дэд станцын 35 кВ-ын бүтээн байгуулалтын ажлыг Зүүн-Өмнөд бүсийн салбарын Засварын албаны дарга Г.Болдхуягаар ахлуулсан 15 хүний бүрэлдэхүүнтэй бригад хийж гүйцэтгэхээр ажиллаж байна.

Уг хоёр дэд станцын өргөтгөлийн ажилтай холбоотой бараа материал 2020 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр Чойр дэд станцад

буулгасныг холбогдох салбарууд хүлээн авч өргөтгөлийн ажлыг 30 хоногт багтаан хийж гүйцэтгэхээр шамдан ажиллаж байна. Хаалттай хуваарилах байгууламжийн барилга угсралтын ажлыг Жеопро Монголиа ХХК хийж гүйцэтгэхээр шалгарч, улаан шугам тавигдаж ажил эхэлсэн байна.



Тавантолгой, Цагаансувraga дэд станцын 35 кВ өргөтгөлийн ажлын бараа материал хүлээлцэж байна



10. АРОЛ АВТОМАТИКИЙГ СУУРИЛУУЛЖ УГСАРЧ АЖИЛЛАГААНД ОРУУЛАХАД БЭЛЭН БОЛГОСОН

ОХУ-аас авах импортын эрчим хүчийг 345 МВт болгон өсгөн нэмэгдүүлэхтэй холбогдуулан 220 кВ-ын 257, 258 дугаар цахилгаан дамжуулах агаарын шугамыг бодит чадлаар хэт ачаалагдах үед ачаалал хөнгөлөх автоматик (АРОЛ)-ийг зайлшгүй ажилд оруулах шаардлага гарсан юм.

257, 258 дугаар цахилгаан дамжуулах агаарын шугамын АРОЛ автоматиктай холбоотойгоор 220/110/35 кВ-ын Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Чойр дэд станцууд болон Ил хуваарилах байгууламж-4 дээр ДҮТ ХХК-ийн WAMS системийг түшиглэн хийгдсэн системийн автоматикийн нэмэлт төхөөрөмжүүдийг суурилуулсан. Тухайн дэд станцууд дээрх АРОЛ автоматикаас цахилгаан дамжуулах агаарын шугамуудыг таслах хэлхээг бодит байдлаар ажиллуулан шалгаж, төлөв байдалд нь үнэлэлт өгч ажилласан. Мөн таслах шугамын хамгаалалтын реле дээр АРОЛ автоматикаас үйлчлэх, дохиолол өгөх, тасралтын үеийн бичлэг хийх, АПВ-д хориг хийгдэх логикуудыг оруулах бэлтгэл


ажил хийгдэж, WAProtector программ дээрээс 257, 258 дугаар шугамын АРОЛ-оор ажиллуулан шугамуудыг тасалж шалгасан.

Шалгалтын ажлыг 2020 оны 05 дугаар сарын 11-ний өдрөөс 05 дугаар сарын 15-ны өдрийн хооронд компанийн Реле хамгаалалт, автоматик, хэмжилт туршилтын хэлтэс, Улаанбаатар, Төвийн бүс, Хангай болон Зүүн-Өмнөд бүсийн салбарын реле хамгаалалт автоматикийн инженерүүд ДҮТ ХХК-ийн инженерүүдтэй хамтран шалгаж ажилд оруулсан.

АРОЛ автоматик нь цахилгаан дамжуулах агаарын шугам 257, 258-аар авах импортын чадлын урсгалыг хянах, тооцсон тавилаас хэтэрсэн тохиолдолд 35 секундын хугацаанд нэгдсэн сүлжээнээс 182.2 МВт таслан ачаалал хөнгөлөх зориулалттай юм. АРОЛ автоматик ажиллах хүрээнд нэгдсэн сүлжээний гуравдугаар зэрэглэлийн хэрэглэгчдийг багтаасан. Уг автоматик нь дохиолох болон таслах гэсэн хоёр шатлалаар ажиллах горимтой.



АРОЛ автоматикийн мэдээлэл хөрвүүлэгч төхөөрөмж суурилагдсан байдал



АРОЛ автоматикийг шалгаж байгаа байдал

13. АПВУС АВТОМАТИКИЙГ АЖИЛЛАГААНД ОРУУЛАЖ

257, 258 дугаар цахилгаан дамжуулах агаарын шугам тасарч Монгол Улсын эрчим хүчний систем ОХУ-аас тусдаа гарсан үед 1-рт давтамж 49 Гц-ээс дээш байх үед АПВУС ажиллаж ОХУ-тай зэрэгцээ ажиллагаанд орно, 2-рт Монголын талд давтамж 49 Гц-ээс доош орсон тохиолдолд АПВУС хийгдэхгүй. Харин АЧР-1, 2 ажиллаж давтамжийг 49 Гц-ээс дээш гаргасан үед АПВУС ажиллаж, ОХУ-тай зэрэгцээ ажиллагаанд оруулах зориулалтаар тавигдсан. 220 кВ-ын ШОН-г багтаамжийн хүчдэлийн трансформатораар сольж 100В хүчдэлээр тэжээх боломжтой болсоноор хүчдэл болон өнцгийн зөрүүг хянах, хурдан үйлчилгээтэй реле хамгаалалтаар хяналт хийх боломжтой болсон. Хоёр системийн А фазын хүчдэлийн векторүүдийн зөрүү нь 1 секундэд буюу нэг бүтэн тойргоор илүү эргэлдэж байна. Өөрөөр хэлбэл ОХУ-ын талын А фазын хүчдэлийн вектор нь Монгол талын давтамжаас 0,1 секунд тутамд -аар түрүүлэхээр харагдаж байна.

$$f_{\text{ОХУ}} = 50 \text{ Гц}$$

А фазын хүчдэлийн вектор 1 секундэд:
50° = эргэнэ.

$$f_{\text{Монгол}} = 49 \text{ Гц}$$

А фазын хүчдэлийн вектор 1 секундэд:
49° = эргэнэ.

14. 110 КВ-ЫН ТЭЛМЭН ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ АГААРЫН ШУГАМЫН ТЗБАХ АЖИЛ

110 кВ-ын Тэлмэн цахилгаан дамжуулах агаарын шугамын тусгаарлагч элемент солих техник зохион байгуулалтын арга хэмжээний ажлыг 2020 оны 07 дугаар сарын 18-ны өдрөөс 2020 оны 07 дугаар сарын 23-ны өдөр хүртэл Хангайн бүсийн салбараас нийт 29 хүний бүрэлдэхүүнтэй өргөтгөсөн бригад гарч тулгуур №350-аас эхлэн 280 ширхэг дундын тулгуурт 7000 ширхэг тусгаарлагч элемент сольсон.

Ажлыг хийж гүйцэтгэсэнээр 110 кВ-ын Тэлмэн цахилгаан дамжуулах агаарын шугамын тусгаарлагч элементийг сольж, хуучирсан тусгаарлагчийн нэвт цохигдсоноос үүссэн шугамын тасралтыг бууруулах боломж бүрдсэн. 110 кВ-ын Баянхонгор цахилгаан дамжуулах агаарын шугамын

анкер №9-72 хооронд дамжуулагч утас /АС-120/ солих ТЗБАХ ажил, мөн төлөвлөгөөт бус их засварын ажил болох чичиргээ намжаагч, шувуу үргээгч суурилуулах ажлыг 2020 оны 08 дугаар сарын 14-ний өдрөөс 2020 оны 08 дугаар сарын 21-ний өдрүүдийн хооронд Хангайн бүсийн салбарын Засварын албаны дарга А.Гомбосүрэн, засварын мастер Ч.Анхдаваа, Хархорины хэсгийн мастер Б.Чагнаадорж нарын удирдлага дор нийт 29 хүний бүрэлдэхүүнтэй өргөтгөсөн бригад хийж дуусгасан. Ингэснээр 110 кВ-ын Баянхонгор цахилгаан дамжуулах агаарын шугамын найдвартай ажиллагаа дээшилж шувуунаас үүдэлтэй шугамын тасралтыг бууруулах, дамжуулагч утасны гэмтэл бууруулах боломж бүрдсэн.

15. 110 КВ-ЫН БАЯНХОНГОР ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ АГААРЫН ШУГАМЫН ИХ ЗАСВАРЫН АЖИЛ

110 кВ-ын Баянхонгор цахилгаан дамжуулах агаарын шугамын анкер №9-72 хооронд дамжуулагч утас /АС-120/ солих ТЗБАХ ажил, мөн төлөвлөгөөт бус их засварын ажил болох чичиргээ намжаагч, шувуу үргээгч суурилуулах ажлыг 2020 оны 08 дугаар сарын 14-ний өдрөөс 2020 оны 08 дугаар сарын 21-ний өдрүүдийн хооронд Хангайн бүсийн салбарын Засварын албаны дарга А.Гомбосүрэн, засварын мастер

Ч.Анхдаваа, Хархорины хэсгийн мастер Б.Чагнаадорж нарын удирдлага дор нийт 29 хүний бүрэлдэхүүнтэй өргөтгөсөн бригад хийж дуусгасан.

Ингэснээр 110 кВ-ын Баянхонгор цахилгаан дамжуулах агаарын шугамын найдвартай ажиллагаа дээшилж шувуунаас үүдэлтэй шугамын тасралтыг бууруулах, дамжуулагч утасны гэмтэл бууруулах боломж бүрдсэн.

16. БАГАНУУР-ЧОЙРЫН 207 ДУГААР ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ АГААРЫН ШУГАМЫН ИХ ЗАСВАР

110 кВ-ын Баянхонгор цахилгаан дамжуулах агаарын шугамын анкер №9-72 хооронд дамжуулагч утас /АС-120/ солих ТЗБАХ ажил, мөн төлөвлөгөөт бус их засварын ажил болох чичиргээ намжаагч, шувуу үргээгч суурилуулах ажлыг 2020 оны 08 дугаар сарын 14-ний өдрөөс 2020 оны 08 дугаар сарын 21-ний өдрүүдийн хооронд Хангайн бүсийн салбарын Засварын албаны дарга А.Гомбосүрэн, засварын мастер

Ч.Анхдаваа, Хархорины хэсгийн мастер Б.Чагнаадорж нарын удирдлага дор нийт 29 хүний бүрэлдэхүүнтэй өргөтгөсөн бригад хийж дуусгасан.

Ингэснээр 110 кВ-ын Баянхонгор цахилгаан дамжуулах агаарын шугамын найдвартай ажиллагаа дээшилж шувуунаас үүдэлтэй шугамын тасралтыг бууруулах, дамжуулагч утасны гэмтэл бууруулах боломж бүрдсэн.

12. 103, 104, 105, 106 ДУГААР АГААРЫН ШУГАМД ГУРВАН ТӨГСГӨЛИЙН ҮНДСЭН ХАМГААЛАЛТ ОРУУЛСАН

105, 106 дугаар цахилгаан дамжуулах агаарын шугамд өндөр давтамжийн пост бүхий хоригийн үндсэн хамгаалалт дээр нэмэгдэж гурван төгсгөлийн хамгаалалт орсоноор системийн найдвартай ажиллагаа хоёр дахин нэмэгдсэн. Шилэн кабелийн суваг болон шилэн кабелийн оролт бүхий реле хамгаалалт автоматикийн төхөөрөмжүүдийг ашиглан бусад ажлыг дотоодын нөөц бололцоогоо ашиглан 110/10/6 кВ-ын Өмнөд дэд станцад МП хамгаалалт нэмж суурилуулан гурван төгсгөлийн хамгаалалтыг оруулснаар Улаанбаатар хотын транзит гол шугамын найдвартай ажиллагааг нэмэгдүүлж чадсан үр дүнтэй ажил болсон.



17. ИХ ТОЙРУУ 110/220 КВ-ЫН ДЭД СТАНЦ, ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ АГААРЫН ШУГАМЫН АЖЛЫН ЯВЦ

Цахилгаан эрчим хүчний өсөн нэмэгдэж буй хэрэглээг хангах, Нийслэлийн барилгажилт, орон сууцны төслүүдийг цахилгаан эрчим хүчээр хангах хүрээнд их тойрог 110/220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих төслийг 2008 оноос эхлэн санаачилж, зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажлыг хийж эхэлсэн. Одоогоор их тойрог сүлжээний 110/35/10 кВ-ын Найрамдал, 110/35/10 кВ-ын 7-р хороолол, 110/10 кВ-ын Буянт Ухаа, 110/35/10 кВ-ын 14-р хороолол,

110/35/10 кВ-ын Зайсан дэд станцууд ашиглалтад орсон.

Өнөөгийн байдлаар газрын маргаантай асуудлын улмаас 127, 128 дугаар цахилгаан дамжуулах агаарын шугамын утсыг татаж чадахгүй байсан хоёр цэгт шугамын утсыг татах, Сонгино дэд станцад 2x125 мВА автотрансформаторыг угсрах, хоёрдогч хэлхээний кабелийн татах, монтажлах ажил хийгдэж байгаа бөгөөд 2020 оны 11 дүгээр сард багтаан бүрэн ашиглалтад оруулахаар ажиллаж байна.



ИХ БОЛОН УРСГАЛ ЗАСВАРЫН АЖЛААР ХИЙГДСЭН АЖЛУУД

2020-2021 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд Төсөл хөтөлбөрийн хэлтэст хийгдсэн трансформатор засварын томоохон ажлууд. Үүнд:

1. 110/10 кВ-ын Улаанхуаран дэд станцаас буусан 10 МВА чадалтай хоёр хүчний трансформаторт их засварын ажлыг гүйцэтгэж ашиглалтад бэлэн болгов. Тус хүчний трансформатор нь шахмал түлшний үйлдвэрийг цахилгаан эрчим хүчээр хангахаар төлөвлөн барилга угсралтын ажил гүйцэтгэгдэж буй дэд станц руу тээвэрлэгдэж, суурилуулагдсан.



2. ПРП-22 агуулахын хашаанд байрлаж байсан 10 МВА хүчний трансформатор болон 110/35/10 кВ-ын Баруунхараа дэд станцаас буусан 6.3 МВА чадал бүхий нөөцөд хадгалагдаж буй хүчний трансформаторуудад урсгал засварын ажлыг гүйцэтгэв.




3. 110/10/6 кВ-ын Өмнөд дэд станцын Т-1, Т-2 хүчний трансформаторыг ПХБ төслийн төхөөрөмжөөр эргүүлэн хатааж, тосны чанарын үзүүлэлтүүд болон хөндийрүүлгийг дээшлүүлэв.



4. Улаанбаатар салбарын 220/110/35 кВ-ын Улаанбаатар дэд станцын АТ-1 автотрансформаторыг ПХБ төслийн төхөөрөмжөөр эргүүлэн хатааж, тосны чанарын үзүүлэлтүүд болон хөндийрүүлгийг дээшлүүлэв.



5. Зүүн-Өмнөд бүсийн салбарын Сайншанд дэд станцын Т-1, Т-2 хүчний трансформаторыг ПХБ төслийн төхөөрөмжөөр эргүүлэн хатааж, тосны чанарын үзүүлэлтүүд болон хөндийрүүлгийг дээшлүүлэв.



6. 110/10 кВ-ын Амгалан дэд станцын гэмтсэн 25 МВА чадалтай Т-2 хүчний трансформаторыг БНХАУ-ын Реорле группийн трансформаторын үйлдвэрт засварлуулахаар тээвэрлэж, 70 хоногийн турш засварлуулсаны дараа буцаан тээвэрлэж Амгалан дэд станцад суурин дээр нь суурилуулан угсарч, ажилд залгав.



7. Украин Улсын ЗТЗ сервис компанийн мэргэжилтнүүдтэй хамтран засварласан 220/110/35 кВ-ын Эрдэнэт дэд станцын 200 МВА чадалтай АТ-2 автотрансформаторыг Улаанбаатар хотоос Эрдэнэт хот руу төмөр замаар бусад дагалдах эд ангиудыг төмөр замаар болон ачааны автомашинаар тээвэрлэх ажлыг Төсөл хөтөлбөрийн хэлтэс, Нийтлэг үйлчилгээ, тээвэр механизмын хэлтэс, Хангайн бүсийн салбар хамтран зохион байгуулан ажиллаж байна.



ТХХ-ийн төсөл хөтөлбөрийн
инженер Ч.Одбаяр